



# mozaBook getting started

- **mozaBook** 2  
*Суулгах, эхлүүлэх, хуудасны тойм  
Нийтлэл нээх  
PDF болон PPT импортлох  
Чигээ олох, Нийтлэлийг шинэчлэх  
Шинэ нийтлэлүүд*
- **Нэмэлт агуулгууд** 14  
*Динамик нэмэлтүүд  
3D үзэгдэл, видео  
Давхрагууд, Хэрэгслүүд, тоглоомууд  
Зургийн хэрэгсэл, Дасгал засварлагч*
- **Дасгалын дэвтрүүд** 34  
*Дэвтрийн хуудсан дээрх үйлдлүүд  
Харилцааны диаграмм, Анимэшн  
Геометрийн хэрэгслүүд, Тэмдэглэлүүд  
холбоосууд, Хөдөлгөөнт загварууд  
mozaWeb дээрх дасгалын дэвтрүүд*
- **Бусад функц** 44  
*Хайх, Тусламжийн хэрэглээ, Мультимедиа  
бичигч, Хэвлэх, Гар бичмэл таних  
Тохиргоо, Гэрийн даалгавар, Ангийн ажил  
mozaBook хэд хэдэн платформ дээр  
mozaBook ба mozaWeb, Программыг  
шинэчлэх, санал хүсэлт илгээх*



### mozaBook гэж юу вэ?

mozaBook нь интерактив сургалтын үзүүлэнг программ ба үүний тусламжтайгаар хялбархнаар, үзэмжтэй хичээл явуулах боломжийг олгодог.



mozaBook-эд цахим номнуудыг гарган уншиж, мөн эдгээрийг хэдхэн товшилтоор цахим агуулгаар (видео, аудио, 3D үзэгдэл, дасгалууд) баяжуулах боломжтой. Ингэхдээ программын зөвлөмжийг ч дагаж хийж болдог. Сонирхолтой танилцуулга, хичээлийн тойм, дасгалын хуудсуудыг бас бэлтгэн, үгээрээ сурагчдынхаа сонирхлыг татаж, хичээлээ улам сайн ойлгуулаарай.


### Энэ программ ямар боломжуудыг санал болгодог вэ?

Уг программд өөрийн дасгалын дэвтрийг үүсгэж болно, гэхдээ өөрийн PDF файлуудыг ч импортолж бас болно. Эдгээртээ бичиж, зураг зурж, бас Медиа сангийн интерактив агуулгыг ашиглан улам үзэмжтэй, сонирхолтой болгож болно. Бэлэн болсон үзүүлэнгээ анимейшний тусламжтайгаар хөдөлгөөнд оруулах боломж ч бий.



mozaBook-ийг интерактив самбар дээр, компьютер дээр, танхимд, гэртээ ч ашиглах боломжтой.

Гэртээ хичээлд хэрэглэх үзүүлэнгээ тухтай бэлтгэн интернэтээр синхрончлоод, дараа нь mozaBook ажилладаг ямар ч хамаагүй компьютерээс хандаж болно.





**Гэртээ суралцахад зориулсан онлайн платформ** mozaWeb нь mozaLearn боловсролын системийн сурагчид, багш нарт бусадтай харьцуулшгүй тусламж үзүүлдэг гэртээ суралцах, хичээлд бэлтгэхэд зориулсан хэсэг юм. mozaWeb-ийг ашигласнаар гэртээ суралцахад үр дүнтэй, сонирхолтой болдог.

- Хялбархнаар бүртгүүлсний дараа mozaWeb-ийн дуу алдам, интерактив ертөнцөд нэвтрэн орж болно, гэхдээ апп-ын функцүүдийг бүрэн дүүрэн ашиглаж чадахын тулд mozaWeb захиалга шаардлагатай.
- Онлайн горимоор, ямар ч хамаагүй интернэт хөтөч ашиглан mozaBook дээр байдаг бүх сургалтын агуулгад хандах боломжтой.
- Цахим сурах бичгүүдээ нээж, хуудсыг нь эргүүлж, хуудасны хэсгүүдийг томруулан харж, сэдэвтэй холбогдох интерактив нэмэлт агуулгуудыг (3D үзэгдлүүд, сургалтын видео, аудио, дасгалууд) тоглуулах боломжтой.



### Медиа сан

Медиа санд байгаа сэдвээр нь ангилсан хэдэн мянган интерактив нэмэлт агуулгуудаас сонгон үзэж болох ба эдгээрийг mozaWeb-ийн суурилуулсан медиа тоглуулагчаар тэр дор нь тоглуулж болно.

- 1300 гаруй интерактив 3D үзэгдэл,
- олон зуун видео,
- зураг, аудио материал, дасгалууд болон бусад нэмэлтүүд.



### Хэрэгслүүд, тоглоомууд

Хичээлээ давтах, олж авсан мэдлэгээ гүнзгийрүүлэхэд харьцуулахын аргагүй тусламж үзүүлдэг 110 гаруй сэдэвчилсэн хэрэгсэл, тоглоомд хандах боломжтой.



## Хялбар суулгалт

mozaBook installer-ийг Mozaik Education-ий вэб хуудаснаас татаж авч болно. Суулгагч программыг эхлүүлээд зааврыг дагаарай ①. Суулгах явц дууссаны дараа программаа ширээн дээр гарсан икон дээр даран эхлүүлэх боломжтой.



## Зөвлөмж

mozaBook нь анхны удаа эхлүүлэхэд худалдаж авсан лиценз кодоо өгөхийг хүсэх болно ②. Хэрвээ танд лиценз код байхгүй бол Демо горимыг сонгоорой ③. Лиценз кодыг оруулахад интернэтэд холбогдсон байх шаардлагатай.


## Системийн шаардлага

### mozaBook

- Ширээний компьютер, эсвэл Notebook
- Microsoft Windows 8.1 буюу үүнээс шинэ хувилбар
- 2 GB сул дискний зай номгүйгээр. Ном тус бүрд онлайн бол номын багцад цаашдын 20-80 MB, офлайн бол 1-2 GB зай шаардлагатай
- Хамгийн багадаа 4 GB санах ой (8 GB RAM байхыг зөвлөж байна)
- CPU: 1.2 ГГц ба түүнээс дээш хурдтай
- 3D болон видеог хурдан тоглуулахад хэрэгтэй график карт
- Дэлгэцийн нягтрал: минимум. 1024x768

## mozaBook лиценз код

Лиценз кодоор та өөрийгөө mozaBook-ийг ашиглах эрхтэй гэдгийгээ нотолно. Нэг лиценз кодоор mozaBook-ийг нэг зэрэг нэг л компьютер дээр ажиллуулах боломжтой. (Дэлгэрэнгүйг 59-р хуудаснаас харна уу.)





## mozaWeb бүртгэл гэж юу вэ?

mozaWeb бүртгэл нь уг бүртгэлийн тусламжтайгаар mozaBook программ доторх Медиа сангийн интерактив агуулгад (3D үзэгдлүүд, видео, аудио, интерактив дасгалууд) хандаж, өөр компьютер дээр үүсгэсэн өөрийн агуулгаа хуваалцаж болох онлайн хэрэглэгчийн бүртгэл юм.

Энэ бүртгэлээрээ mozaWeb-д нэвтрэн орж, бүх сурах бичигтээ, интерактив агуулгад mozaBook программын шаардлагагүйгээр онлайн ч хандах боломжтой. Хэрвээ танд mozaWeb бүртгэл байгаа бол хэрэглэгчийн нэр, нууц үгээрээ нэвтрэн орно уу ①.

Хэрвээ бүртгэл байхгүй бол өөрийн mozaWeb онлайн бүртгэлээ үүсгэнэ үү.

**Зөвлөмж** • mozaWeb онлайн бүртгэлдээ дасгалын дэвтрээ байршуулан, эдгээр дэвтрээ mozaBook ажилладаг ямар ч хамаагүй компьютер дээр нээж болно. Дэвтэртээ оруулсан өөрчлөлтийг автоматаар бүртгэлд тань хадгалахыг программд тохируулах боломжтой, ингэснээр таны дэвтрүүд үргэлж синхронд байх болно.





## mozaWeb бүртгэл үүсгэх

mozaBook-ийг анх эхлүүлэхдээ Шинэ бүртгэл үүсгэх товчин дээр даран ② өөрийн mozaWeb онлайн бүртгэлээ үүсгээрэй.

Өөрийн мэдээллээ оруулан ③, Үүсгэх товч дээр дараарай ④.

Таны хэрэглэгчийн нэр болон нууц үгийг имэйлээр илгээх ба үүгээр mozaWeb порталд ч нэвтрэн орох боломжтой.

mozaWeb бүртгэлээ үүсгэхэд хэрэглэгчийн нэр, нууц үг автоматаар үүсгэгдэнэ, гэхдээ нууц үгээ mozaWeb-рүү нэвтрэн орсны дараа Профайл цэсэнд өөрчлөх боломжтой.





### mozaBook дотоод хэрэглэгч үүсгэх

mozaBook-ийг компьютер дээрээ хэрэглэхийн тулд дотоод хэрэглэгчийг үүсгэх шаардлагатай. Энэ хэрэглэгчээр нэвтэрч орон программыг эхлүүлж болно.

Үүний дараа

- өөрийн дасгалын дэвтрээ үүсгэж,
- нийтлэлд оруулсан өөрчлөлтүүдээ хадгалж,
- интерфэйсийг өөртөө тохируулах боломжтой.

Хэрэглэхийг хүссэн хэрэглэгчийн нэр ①, нууц үгээ оруулан ②, аватараа сонгоорой ③!





### mozaBook-ийн хэд хэдэн дотоод хэрэглэгч

Нэг компьютер дээр mozaBook-ийн хэд хэдэн дотоод хэрэглэгчийг үүсгэж болно. Хэрэглэгчийн бүртгэлдээ

- өмнө байсан mozaWeb бүртгэл ④,
- шинэ mozaWeb бүртгэлээ холбож болно ⑤, гэхдээ энэ алхмыг алгасаж ч бас болно ⑥.

mozaWeb хэрэглэгчийн бүртгэлээ mozaBook-ийн Тохиргооны самбарт mozaWeb бүртгэл цэсэнд ⑦ ч бас өгөх боломжтой.



### Зөвлөмж

Хэрвээ mozaBook-ийг хэд хэдэн компьютер дээр ашигладаг бол дотоод хэрэглэгчдээ нэг ижил mozaWeb бүртгэлд холбосон нь дээр, учир нь ингэвэл бүх компьютер дээр адилхан зүйлсийг харах боломжтой болно.



## Нэвтрэн орох

mozaBook-ийг ямар хэл дээр ашиглахаа сонгоорой ①, мөн шаардлагатай бол ашигладаг хэрэгслүүддээ тааруулан томруулгыг тохируулаарай ②. Аватараа сонгоод ③, нууц үгээ оруулаарай ④!

- Аль нийтлэлийг нээхээ сонгож болно ⑤.
- Шинэ дасгалын дэвтэр үүсгэж болно ⑥.
- Хийж байсан зүйлээ өмнө нь орхисон газраасаа үргэлжлүүлж болно ⑦.
- Хэрвээ хүсвэл бас дахин шинэ дотоод хэрэглэгч үүсгэж ч болно.



## Нийтлэл сонгох

Цонхны доод талд байгаа зураасыг гүйлгэн хандаж болох номнууд, дасгалын дэвтрүүдээс сонгож болно. Хэрвээ жагсаалт нь хэт урт бол сэдвээр, ангиар эсвэл нийтлэлийн төрлөөр нь шүүлтүүр хийж болно ⑧.

Нийтлэлийг нээхийн тулд хавтсан дээр нь, эсвэл Нийтлэлийг нээх икон дээр дарна уу ⑨. Мөн энд бас Дасгалын шинэ дэвтэр үүсгэх, эсвэл Сүүлчийн төлөвийг нээх функцүүдийг сонгож болно.

Программыг хаахын тулд, эсвэл нэвтрэх хуудасруу буцахын тулд баруун дээд буланд байгаа х икон дээр дараарай ⑩.



### 1. Нийтлэлийн таб-ууд

Нэг зэрэг хэд хэдэн нийтлэл нээж болно, таб дээр даран аль нь идэвхтэй байхыг сонгох боломжтой.

### 2. Хэрэгслүүд

Дүрслэн үзүүлэх болон шалгах зорилгоор хийсэн сэдэвчилсэн туслах материалууд, ур чадвар хөгжүүлэх болон логикийн тоглоомууд. Хэрэгслүүдийн бичвэрийн болон зурган агуулгуудыг mozaBook-ийн дасгалын дэвтрүүдэд, нийтлэлүүдэд импортлох боломжтой.

### 3. Тохиргоо

Тохиргооны самбарыг ашиглан программыг өөрийн хэрэгцээнд тохируулах боломжтой. Энэ нь таны ажлыг илүү хурдан, эвтэйхэн болгоход тусална.

### 4. Хэрэгслийн сан

Хэрэгслийн сангаас програмын чухал функцүүдэд хандаж болно.

### 5. Дасгалын дэвтрийн шинэ хуудас

Энд шинэ дасгалын дэвтрэр үүсгэж, эсвэл нээсэн дэвтрэтээ шинэ хуудас оруулж болно.

### 6. Медиа сан

Интерактив агуулгууд, 3D үзэгдлүүд, зураг, видео болон аудио материалууд дотор хайж, сонгож болно.

### 7. Мультимедиа бичигч

Дэлгэцийн агшинг, эсвэл үүний нэг хэсгийг хадгалж болох ба дууны болон видео бичлэг хийх боломжтой.

### 8. Тусламж

mozaBook-ийн тусламж дотор уг программын бүх функцийг хэрэглээний талаар бичсэн туслах материал бий. Видео тусламжийн дэмжлэгтэйгээр программыг болон хэрэгслүүдийг хэрхэн ашиглахыг хялбархан сурч авч болно.

### 9. Идэвхтэй хэрэгслүүд

Сонгосон хэрэгслүүдийг иконоор, эсвэл өнгөц зургаар номонд, дэвтэрт оруулан, дараа нь тэндээсээ нээж байх боломжтой.

### 10. Тавиур

Нээсэн нийтлэлүүдэд, цонхнуудад эндээс үргэлж хандаж болно.

### 11. Үзэгний сав

Эндээс зургийн хэрэгслүүдэд хялбархан хандаж болно. Дэлгэцэн дээрээс сонгосон зүйлийг хогийн сав руу чирэн оруулж хялбархнаар устгах боломжтой.

### 12. Чимэглэх зургийн хэрэгсэл

Суурилуулсан зургийн функцүүдээр сурах бичгүүд, номуудыг чөлөөтэй чимэглэх боломжтой.







## 1. Нийтлэлүүдийг хаанаас олох вэ?

Хэрэгслийн сан дахь Нээх иконыг дараарай ①. Номууд цэсэн дээр дарахад ②, хандаж болох ботиуд гарч ирнэ. Таб-уудын тусламжтайгаар цонхонд номууд, эсвэл дэвтрүүд гарч ирэхийг сонгож болно ③.

## 2. Нийтлэлийг хэрхэн нээх вэ?

Нийтлэлийг нээхийн тулд дээр нь дараарай ④. Хэрвээ жагсаалтад хэт олон нийтлэл байгаа бол хуудасны толгой хэсэгт байгаа шүүлтүүрээр хичээлийн сэдвээр юмуу ангиар шүүх боломжтой ⑤.


 Импорт / Экспорт цэсэнд ⑥ PDF-ийг ч бас нээж, нээсний дараа дасгалын дэвтрийн нэгэн адилаар хэрэглэх боломжтой.



## 3. Нээсэн нийтлэлүүдийн хооронд хэрхэн шилжих вэ?

Төв хуудасны толгойн хэсэгт байгаа таб-ууд дээр дарж аль нийтлэлийг цонхонд харуулахыг сонгоорой ⑦.

Нийтлэлүүдийн хооронд хэрэгслийн сан дээр байгаа Тавиур икон дээр дарж бас шилжих боломжтой ⑧.



## 4. Нийтлэлүүдээ хэрхэн хадгалах вэ?



Хэрэгслийн сан дээрх Нээх икон дээр дарахад гарч ирэх самбарын цэснээс Хадгалах хэсгийг сонгоорой ⑨.

Тавиур иконыг сонгоод ⑧, нийтлэлийн нэрийн дэргэд байгаа Хадгалах иконоор ч бас сонгосон нийтлэлээ хадгалах боломжтой.

## 5. Нийтлэлүүдээ хэрхэн хаах вэ?

Нийтлэлийг харуулах таб дээр нийтлэлийн нэрийн хажууд байгаа х тэмдэг дээр дараарай ⑩.

Мөн нийтлэлийг Тавиур-аас ч хаах боломжтой ⑪.







## PDF болон PPT импортлох функц

mozaBook программд PDF болон PPT (PowerPoint) файлуудыг импортлох боломжтой. Сканируулаар уншуулж оруулсан файлууд нь mozaBook номууд болон программ дээр үүсгэсэн дасгалын дэвтрүүдтэй адил ажиллагаатай байх болно. Эдгээрийг дэлгэц дээр гаргах, хуудсыг нь эргүүлэх, хуудасны хэсгүүдийг томруулах боломжтой ба хуудсанд нь mozaBook-ийн Медиа сангийн интерактив агуулгаас оруулж ч бас болно.

- Импортлосон PPT файлын үзүүлэнгүүдийг (хуудаснуудыг) нэмэн засварлаж болно.
- Хэрвээ таны хэрэглэдэг сурах бичиг PDF форматаар бас байгаа бол импортлон оруулаад mozaBook программ дээр бас хэрэглэх боломжтой.




## PDF импортлох

Хэрэгслийн сан дээр Нээх икон дээр дараарай ①.  
Импорт / Экспорт цэсэн дотроос ② PDF импорт хэсгийг дараарай.  
Гарч ирэх Медиа сангийн цонхноос нээхийг хүссэн файлаа хайж олоорой ③.  
Өөрийн компьютер дээр болон ④ интернэтээс ч бас ⑤ хайж боломжтой.  
Сонгосон PDF файлаа Импорт, эсвэл Татаж авах товчин дээр даран нээж болно ⑥.

## PDF файлыг mozaBook-ийн дасгалын дэвтэр болгон хадгалах

Импортлосон PDF файлуудыг дасгалын дэвтэр болгон хадгалах боломжтой ⑦.  
Гарчиг өгөөд, хавтасны зураг, сэдэв, ангийг нь тохируулаад, агуулгынх нь талаар товч мэдээлэл оруулаарай. Энэ PDF файлаа дараа нь нээх боломжтой нийтлэлүүдийн дундаас олж болно.





## 1. Чигээ олох үндсэн функцүүд

Нийтлэлийг нээсний дараа хуудас эргүүлэх сумуудаар ① хуудсыг урагшаа, хойшоо эргүүлж болох ба Хэрэгслийн сан дээр байгаа Хуудасны дугаар цэсний тусламжтайгаар ② хүссэн хуудас руугаа шилжих боломжтой.

## 2. Агуулгын жагсаалт, хуудаснуудын өнгөц зургууд

Хэрэгслийн сангийн Агуулгын жагсаалт икон дээр ③ дарахад хамаарах агуулгын жагсаалт гарч ирэх болно. Бүлгүүдийн нэрэн дээр дарахад программ нь тэр хуудасруу шилжинэ. Толгойн хэсэг дэхь таб-уудын ④ тусламжтайгаар. Агуулга болон Хуудаснууд (хуудаснуудын өнгөц зурагнууд) харагдцын хооронд шилжих боломжтой. Сонгосон хуудасны өнгөц зурган дээр даран ⑤ уг хуудасруу шилжиж болно.


## 3. Харагдах байдал, томруулах

Хуудасны хэсгүүдийг, текстийн хайрцгуудыг, зурагнуудыг дээр нь товшин тодруулах, томруулан харах боломжтой.

Хуудасны харагдац самбараас ⑥

- хуудасны хэсгүүдийг томруулах,
- нэг болон хос хуудасны харагдац руу шилжих,
- хэрвээ хэд хэдэн нийтлэл нээлттэй байгаа бол хоёр нийтлэлийг зэрэг харах харагдацыг ч бас тохируулах боломжтой.



Хоёр нийтлэлийн харагдацад толгой хэсэг дэхь сумыг ⑦ даран нийтлэлүүдийг солих боломжтой. Нэгэн зэрэг хамгийн дээд тал нь 6 нийтлэл нээлттэй байж болдог.



## 4. Халхлах

Үзүүлэн үзүүлж байх үед зарим нэг хуудасны хэсгийг болон бүхэл хуудсыг түр зуур халхлах ⑧, ар дэвсгэрийг алга болгох эсвэл харанхуйлах нь ихэд дэм болох үе байдаг. Энэ функцийг ашиглахын тулд Хэрэгслийн сангийн Халхлах икон дээр дараарай ⑨.

Тэгш өнцөгт юмуу эллипс хэлбэртэй халхлалтаас сонгож болох ба үүний хэмжээг нь өөрчилж, хуудасны аль хэсэгт байрлуулах, эсвэл урвуу халхлалт ⑩ бас үүсгэх боломжтой.






## Нийтлэлийг шинэчлэх

Захим нэг mozaBook нийтлэлийн агуулга нь өөрчлөгдөх (ж нь: шинэ мэдээлэл, нэмэлт нэмэгдэх) тохиолдол гардаг, иймээс уг нийтлэлүүдийг шинэчлэх шаардлагатай болдог.

mozaBook нь нэвтэрч орсны дараа нийтлэл сонгох интерфэйс дээр таны компьютер дээр татагдсан нийтлэлүүдийн аль нэгийн шинэ хувилбар бий болсныг мэдэгдэх болно ①.

Уг нийтлэлийг сонгон, Татаж авах ② дээр даран хялбархнаар шинэчлэх боломжтой.



**Зөвлөмж** • Нээх самбарын Номууд цэсийг ③ сонгон нийтлэлүүдийнхээ төлөвийг байнга хянаж, шинэчлэлт, татан авалтыг удирдаж байх боломжтой ④.

## Дасгалын дэвтрийг шинэчлэх (синхрончлох)

Хэрвээ та дэвтрийнхээ автоматаар синхрончлох функцийг ашигладаг бол программ нь номны шинэчлэлийн нэгэн адилаар таны бүртгэлд компьютер дээр байгаагаас илүү шинэ хувилбар байгааг мэдэгдэх болно. Үүний тусламжтайгаар та дэвтрээ байнга синхронтой байлгах боломжтой.




## Шинэ нийтлэл худалдан авах

Шинэ mozaBook нийтлэлүүдийг mozaWeb-ийн вэб дэлгүүрээс худалдан авч, дараа нь mozaBook програмын тусламжтайгаар компьютеррүүгээ татан авч, ашиглах боломжтой.

- Худалдан авалт хийхийн тулд mozaWeb-д бүртгэлийнхээ хэрэглэгчийн нэр, нууц үгээрээ нэвтрэн ороорой.
- Вэб дэлгүүрээс худалдан авах боломжтой цахим нийтлэлүүдээс сонгон, зааврыг даган худалдаж аваарай.
- Худалдан авалт амжилттай болсны дараа нийтлэлийн идэвхжүүлэх кодыг бид таны имэйл хаягруу илгээх болно.

## Зөвлөмж

mozaBook дээр вэб дэлгүүр нээхийн тулд Шинэ нийтлэл оруулах икон ① дээр дараад, Онлайн худалдан авах хэсгийг сонгоорой ②.




## mozaBook-рүү шинэ нийтлэл татаж авах

- Нийтлэл худалдан авсны дараа идэвхжүүлэх кодыг нь mozaWeb бүртгэлдээ оноосон бол, mozaBook-рүү уг бүртгэлтэй холбоотой дотоод хэрэглэгчийн ID гаар нэвтрэн ороорой.

Програм нь нийтлэлийг шинэчлэхийн нэгэн адилаар, нийтлэл сонгох интерфэйс дээр шинэ нийтлэл гарсан байгааг мэдэгдэх болно ③. Нийтлэлийг сонгоод, Татаж авах икон ④ дээр дараарай.



- Хэрвээ таны хүлээж авсан идэвхжүүлэх код нь mozaWeb бүртгэлд тань оноогдоогүй байгаа бол Шинэ нийтлэл оруулах цэснээс Идэвхжүүлэх код оруулах функцийг сонгоорой ⑤. Гарч ирэх самбарт нийтлэлийн кодыг оруулан ⑥, татаж аваарай! Уг нийтлэл нь таны mozaWeb бүртгэлд оноогдох тул энэ нийтлэлдээ өөр компьютер дээрээс ч хандах боломжтой.





## Нийтлэлүүдийн интерактив агуулгууд

mozaBook нийтлэлүүдэд урьдчилан бэлтгэсэн үзүүлэнгийн материалууд, цахим агуулгуудын (3D үзэгдлүүд, видео, аудио материалууд, зураг, интерактив дасгалууд гэх мэт) иконуудыг 1 байрлуулсан байдаг, эдгээрийг уг иконууд дээр даран нээх боломжтой.

- Хичээлийг үзэмжтэй болгон, дүрслэн үзүүлэхийн түвшинг дээшлүүлэн хичээлээ заан сургах явдлыг илүү амжилттай болгодог.

## 3D үзэгдлүүд 2

Эдгээрийн тусламжтайгаар дээр үеийн болон өнөөгийн ажлын багажууд, машинуудын талаар суралцаж, устан алга болсон эрин үед зочлон, хүний биеийн нууцыг нээн, химийн ертөнцтэй танилцах боломжтой.

- Томруулж харах, эргүүлэх боломжтой 3D загварууд.
- Хэрэглэгчийн нэгдмэл интерфэйс, хэрэглээг нь хялбархан сурч авч болно.
- Маш олон үзэгдлүүдийг хүүрнэл бүхий анимейшний тусламжтайгаар тойрон үзэх боломжтой.

## Видеонууд 3

Нийтлэлд оруулсан видеонуудын дунд:

- физик, хими болон биологийн туршлагаудын талаарх видеонууд,
- байгалийн сэдэвт видео, баримтат кино, сургалтын видеонууд,
- үлгэрүүд, уран зохиолын бүтээлүүд, киноны хэсэглэлүүд болон бусад видеонууд байдаг.


Нийтлэлүүд нь заримдаа аудио материалууд, зургууд, тайлбар зургууд болон интерактив дасгалуудыг агуулдаг.



## Өөрийн агуулгууд, дасгалын хуудсууд

Нийтлэлүүд дотор байгаа нэмэлтүүдийн зэрэгцээгээр Медиа сангаас өөрийн дуртай агуулгыг нэмэн оруулах ч боломжтой. Дасгал засварлагч юмуу хэрэгслүүдийг ашиглан үзэмжтэй дасгалын хуудсуудыг 4 үүсгэн нийтлэлдээ оруулж, эсвэл гэрийн даалгавар болгон өгч болно.





## Динамик нэмэлтүүд

mozaBook нь нээсэн нийтлэлийг, PDF файлыг автоматаар, нийтлэлийн агуулгад тохирсон нэмэлт агуулгаар баяжуулах чадвартай.

Хэрэгслийн сангийн Нэмэлтүүд икон дээр даран ①, гарч ирэх самбар дээр Динамик нэмэлтүүдийг идэвхжүүлээрэй ②.




## Хэрхэн сонгох вэ?

Динамик нэмэлтүүд цонхонд ③ программ нь нийтлэлтэй холбогдох нэмэлтүүдийг санал болгодог. Жагсаалтын зүйлс дээр хоёр товшин ④ нээж, өөрт тохирох агуулгуудыг олоорой.

## Хайлтын үр ашгийг хэрхэн сайжруулах вэ?

- Хайлтын илэрцийг дэргэд байгаа одны өнгийг өөрчлөн үнэлээрэй ⑤!
- Түлхүүр үг нэмэн ⑥, жагсаалтыг шинэчлээрэй ⑦!

Сонгосон нэмэлтийг дэвтэр, номын хуудас руугаа шууд чирэн оруулж ⑧, дараа нь тэндээсээ нээх боломжтой.



## Зөвлөмжүүд


- Хэрвээ санал болгосон нэмэлтүүд дундаас өөрт тохирохыг олоогүй бол Медиа санг ⑨ самбараас шууд нээн тэндээс хайлтаа үргэлжлүүлж болно.
- PDF файлыг имдортлох үед бас динамик нэмэлт функцийг идэвхжүүлбэл нээсний дараа автомат нэмэлтүүдийн жагсаалтыг тэр дор нь харах боломжтой.



## 1. 3D агуулгуудыг хаанаас олох вэ?

Хэрэгслийн сан дээрх Медиа сан иконыг дараад ① 3D үзэгдэл цэсийг сонгоорой ②. Нээгдэх Медиа сангийн цонхноос сонгосон 3D үзэгдэл дээр хоёр товшин нээх, эсвэл шууд нээлттэй нийтлэл рүүгээ чирэн оруулах боломжтой.


Сэдвээр хайх ③



## 2. Шүүх, хайх

Гарч ирсэн агуулгуудыг доош гарч ирэх цэсэнд сэдвээр нь ③ болон ангиар нь шүүж болно.

Хэрвээ нэг тодорхой 3D үзэгдлийг хайж байгаа бол Хайх-ыг сонгоорой ④!



①




## 1. 3D агуулгуудыг хаанаас олох вэ?

Хэрэгслийн сангийн Хэрэгслүүд иконыг даран ①, 3D цэсийг сонгоорой ②. Гарч ирэх хөдөлгөөнт ханыг хуруугаараа хөдөлгөн 3D үзэгдлүүдээс сонгож болно.

## 2. 3D агуулгыг хэрхэн хайх вэ?

Цонхны доод талд байх иконуудыг ашиглан сэдвээ сонгоорой ③! Хөдөлгөөнт хана нь сонгосон ангиллын 3D агуулга руу очих болно. Ангиллын нэр дээр даран уг сэдвийн бусад үзэгдлүүдийг гаргаад, дундаас нь сонгоорой ④.



Сэдвээр хайх ③

## 3. 3D үзэгдлийг нээх

Сонгосон 3D агуулга дээр товшиход томрон харагдах ба Эхлүүлэх товч дээр ⑤ дарахад тоглож эхлэх болно. Томорсон зурагны өөр хэсэг дээр даран хөдөлгөөнт хана руу буцан очих боломжтой.







## Тохиргооны өргөн сонголт


3D тоглуулагчийн ажиллагааны тохиргоог өөрчлөх боломжтой.

- Цонхны зүүн эсвэл баруун захыг дээш доош хөдөлгөн үзэгдлийг томруулж, жижигрүүлж болно ①, эсвэл хоёр хуруугаараа ч тохируулах боломжтой.
- Цонхны дунд хэсгийг хөдөлгөн загварыг эргүүлж болно ②, ийнхүү өөрт таалагдсан талаас нь харах боломжтой.
- Доод хэсэгт өөр загварууд болон урьдчилан тохируулсан харагдцуудаас сонгоорой ③.
- Түргэн цэснээс цаашдын тохиргооны сонголтуудыг олж болох ба уг цэсийг зүүн болон баруун доод булан дээр товшиж, эсвэл цонхны хаана ч даран гаргаж болно ④.



## Зөвлөмжүүд

Цонхны дээд талд байрлах иконуудын тусламжтайгаар тухайн 3D-д хамаарах мэдээллүүд, шошгонуудыг гаргах, эсвэл холбогдох загваруудын хооронд сонгох боломжтой ⑤. Түргэн цэсэнд унших функцийг идэвхжүүлэн ⑥, үзэгдлүүдийн шошгонууд дээр даран ⑦ тэдгээрийг сонсож болно. 3D-д суурилуулсан анимейшнийг үзэж, хүүрнэлийг сонсоорой ⑧. Доод талд байрлах Асуулт Хариулт товчин дээр даран агуулгад холбогдох асуултуудад хариулж ⑨, төрөл бүрийн дасгалыг бодох боломжтой.






## Тойрон алхах функц

Зарим нэг 3D үзэгдэлд Тойрон алхах икон дээр даран ① уг үзэгдлийг тойрон алхаж үзэх боломжтой байдаг.

- Дэлгэцийн доод хэсэгт байгаа joystick-ийн ② тусламжтайгаар жишээлбэл Акрополисыг тойрон алхах юмуу Бастиль цамхгаас алсын барааг харж үзэж болно.
- Тойрон алхаж болох хэсгийн энд тэнд цэгэн дээр даран шууд очих боломжтой.

**Зөвлөмж** • 3D анимешнийг тоглуулах үедээ Дэлгэцийн агшин икон дээр даран ③, тухайн үзэгдлийг зураг болгон дасгалын дэвтэртээ, эсвэл номдоо байрлуулах боломжтой. Зургийн хэмжээг өөрчилж, шилжүүлж, түргэн цэснээс нээж ч болно.




## Нийтлэлүүдийн хуудсан дахь интерактив моделиуд

Зарим нэг интерактив, эргүүлж болох гурван хэмжээст моделиудыг дасгалын дэвтэр, номын хуудсанд оруулж болох ба оруулсны дараа ар дэвсгэр, хүрээгүйгээр бие даан ажилласан хэвээр байх болно.

Үзэгдлийн толгой дээрх Ном икон дээр даран ④, сонгосон хэсгийг ⑤ нийтлэлийнхээ хуудас руу чирэн оруулаарай ⑥.








## 1. Видеонуудыг хаанаас олох вэ?

Хэрэгслийн сан дээрх Медиа сан иконыг 1 даран Видео цэсийг сонгоорой 2.

Нээгдэн гарах Медиа сангийн цонхноос сонгосон видеон дээрээ хоёр товшин тоглуулах боломжтой.



## 2. Хайх, тоглуулах

Сэдэв... цэсэнд 3 сэдвээр ангилан хайж болно. Хэрвээ нэг тодорхой видео хайж байгаа бол Хайх талбарыг 4 сонгох, эсвэл тоглуулагчийн хайгчийг 5 бас ашиглаж болно.


Видеог хоёр товшин тоглуулж, эсвэл нээсэн нийтлэлдээ чирж оруулж, байрлуулж 6 болно. Холбогдох видеонуудын дотор цаашдын сонирхолтой агуулгуудаас сонирхож үзээрэй 7.

Сэдвээр хайх



## Зөвлөмж


Та видеог нийтлэлдээ жижиг, эсвэл том икон, зураг, эсвэл интерактив зүйл болгон оруулах боломжтой.







## 1. Видеонуудыг хаанаас олох вэ?

Хэрэгслийн сангийн Хэрэгслүүд иконыг даран ①, Видео сан цэсийг сонгоорой ②.



Гарч ирэх Видео санг хуруугаараа хөдөлгөн видеогоо сонгоод, дээр нь даран тоглуулаарай ③.






## 2. Хайх, тоглуулах

Видео сангийн доод талд байгаа сэдвүүдийн иконууд дундаас сэдвээ сонгоход видео сан нь сонгосон сэдэв дээр урсан очно ④. Сэдвийн нэр дээр даран цаашдын видеонуудыг гарган дундаас нь сонгох боломжтой.

Видеон дээр даран тоглуулаарай! Дэлгэцийн голд даран видеог түр зогсоож, дахин тоглуулах боломжтой ⑤. Цонхны баруун, эсвэл зүүн тал дээр даран видеог урагш, хойш гүйлгэж болно ⑥.

### Зөвлөмжүүд ⑦

-  Бүтэн дэлгэцийн горимд шилжиж болно.
-  Холбогдох видеонуудыг харж болно.
-  Видео сан руу буцан очиж болно.



## 1. Нийтлэл дэх давхрагууд


Нийтлэлүүд дэх бие бие дээрээ давхарласан, асааж унтрааж болох давхаргууд нь үндсэн нийтлэлийг төрөл бүрийн агуулгаар баяжуулдаг.

- mozaBook нь нийтлэлд холбосон давхарга дээр (Mozaik нэмэлтүүд) ① төрөл бүрийн нэмэлт агуулгыг (зураг, видео, 3D үзэгдэл, дасгал гэх мэт.) хадгалдаг.
- Зарим нэг нийтлэл нь хариултын давхаргыг (Хариултууд) бас агуулдаг.
- Та ч бас нийтлэл дээр зураг зуран, хэсгийг нь тодруулан, эсвэл нэмэлт агуулга оруулан өөрийн давхаргуудыг (Миний давхаргууд) ② үүсгэх боломжтой.
- Мөн бусдын хуваалцсан давхаргыг ч бас (Хэрэглэгчдийн давхаргууд) ③ ашиглаж болно.

## 2. Давхаргуудыг ашиглах

Давхаргуудыг удирдахын тулд Хэрэгслийн сангийн Давхаргууд икон дээр ④ дараарай.

Энэ цэсэнд уг нийтлэлд холбогдох, хандах боломжтой давхаргуудыг харж, гарган үзэх боломжтой.




**Зөвлөмж** • Холбогдох агуулгууд дэд цэснээс ⑤ Цаашдын, нийтлэлийн агуулгад тохирох дасгалын дэвтрүүдийг болон дасгалуудыг Медиа сангийн тусламжтайгаар нээх боломжтой.



## 3. Синхрончлох, хуваалцах

Та өөрийн давхаргуудыг mozaWeb-д байршуулан нийтэд нээлттэйгээр тохируулснаар бусад хүмүүсийн өмнө нээлттэй болгож болно. Ингэхийн тулд Хэрэгслийн сангийн Нээх икон дээр ⑥ даран Хуваалцах цэсийг ⑦ сонгоорой.

Автоматаар синхрончлох ⑧ боломжийг сонгосноор таны өөрийн давхаргууд автоматаар таны mozaWeb онлайн бүртгэлд хадгалагдах болно, ийнхүү таны давхаргууд үргэлж синхронд байх болно. Хэрвээ интернэтэд холбогдоогүй байгаа бол Синхрончлох цэсэнд flash drive-ын тусламжтайгаар бас синхрончлох боломжтой ⑨.







## 1. Хэрэгслүүдийг хаанаас олж болох вэ?

Хэрэгслийн сан дахь Хэрэгслүүд иконыг дараарай ①.



Таб-уудыг ашиглан хэрэгслүүд болон тоглоомуудын хооронд шилжих боломжтой ②.





## 2. Тохирох хэрэгслээ олоорой

Хэрэгслүүдийг сэдвээр болон ангиар шүүх боломжтой ③. Харагдах байдлыг сольж ④, хэрвээ хэрэгслийг ашиглахад тусламж хэрэгтэй бол mozaBook тусламжийг, эсвэл видео тусламжийг ашиглаарай ⑤. Хэрвээ нэг хэрэгслийг дуртай гэж тэмдэглээд, тохирох эрэмбэллийг сонгосон бол ⑥, уг хэрэгсэл жагсаалтын эхэнд гарч ирэх болно.

## 3. Байдлыг хадгалах, хэрэгсэл оруулах

Хэрэгслийн одоогийн байдлыг (ж нь. нэг туршилтын бэлтгэлийг юмуу нэг тохируулсан харагдцыг) хэрэгсэлд зориулсан Оруулах цэсийн ⑧ тусламжтайгаар нээлттэй байгаа нийтлэлд оруулах боломжтой. Хэрэгслийг жижиг, том икон болгон ⑨, эсвэл зураг болгон оруулж, дараа нь нээж болно. Хэрвээ хэрэгслийг интерактив зүйл болгон ⑩ оруулбал уг хэрэгсэл нь дэвтрийн хуудсан дээр бас ажилласан хэвээр байх болно.

**Зөвлөмж** • Хэрэгслийн бичигт болон зурагт агуулгыг дасгалын дэвтэртээ, сурах бичигтээ чирэн оруулж болох ба ингэснээр эдгээрийг танилцуулга, үзүүлэн бэлтгэх туршдаа ашиглах боломжтой ⑪.






## Ур чадвар хөгжүүлэх тоглоомууд ▼

Энэхүү хэрэгслүүд нь бага насны сурагчдын ур чадварыг хөгжүүлэхэд тус дэм үзүүлдэг. Тэдний сонирхлыг татаж, сурсан мэдлэгийг нь тоглоомт хэлбэрээр давтуулах болно.

**mozaTools**  
Үржүүлэхийн хүрд



## Дадлага хийх хэрэгслүүд


Эдгээр хэрэгслүүд нь хичээл дээр сурсан зүйлсийг давтан дасгал дээр хэрэгжүүлэх боломжийг олгодог. Бодсон бодлогуудын амжилттай болсон эсэхийг программ үнэлэн хадгалж, сурагчид тэр дор нь үр дүнгээ харах боломжтой.

## Дүрслэн үзүүлэх хэрэгслүүд ▶

Эдгээр цуглуулгууд нь зорилтот, сэдэвчилсэн хэрэглээний боломжийг олгодог. Үүнд нэг нэг сэдвийг заахад шаардлагатай бүх хэрэгсэл багтсан байдаг.



**mozaTools**  
Хөгжмийн зэмсгүүд



**mozaTools**  
Цахилгаан хэрэгсэл

## ◀ Виртуал туршилтын хэрэгслүүд

Эдгээр цогц хэрэгслүүд нь интерактив самбар дээр, эсвэл компьютер дээр бодит туршилтыг дуурайлган хийх боломжийг олгодог. Үүгээр та чөлөөтэйгөөр хамгийн олон янзын туршилтын төхөөрөмжүүдийг бий болгож болно.



## Цаг хугацаагаар аялах



Цаг хугацааны машин нь алдартай, түүхэн хүмүүсийг төрөл бүрийн харагдах байдлаар харуулдаг.

Цаг хугацааны шугамт харагдац • уг хүмүүсийг цаг хугацааны шугаман дээр үйл ажиллагаагаар нь бүлэглэн харуулна ①.

Харилцааны харагдац • нэг онцолсон хүнээс эхлэн шүүлтүүрийн шалгуурын дагуу 30-40 хүнийг харуулна. Шүүлтүүрийн шалгуурын чухал байдлыг Тохиргоо цэсэнд иконьг хөдөлгөн өөрчилж болно ②.

## Хэрхэн ажилладаг вэ?

Цаг хугацааны машин хэрэгслийг нээгээрэй. Цаг хугацааны шугамыг хөдөлгөн түүхийн алдарт хүмүүсийг харж болно. Хэрэгслийн сан дахь иконуудаар ④ харагдцуудын хооронд шилжих боломжтой. Хэрвээ нэг тодорхой хүнийг хайж байгаа бол Хайх талбарыг сонгоорой ⑤.




Нэг хүн дээр даран ⑥ гарч ирэх цонхноос ⑦ цаашдын функцүүдэд хандах боломжтой.

- ⑧ Тухайн хүнийг онцгойлон харилцааны харагдац руу шилжиж болно.
- ⑨ Wikipedia дээр тухайн хүний талаарх нийтлэлийг нээж болно.
- ⑩ Тухайн хүнтэй холбоотой цаашдын мэдээллүүдийг, үйл явдлуудыг гаргаж болно.

## Асуулт Хариултын тоглоом

- Дасгал икон дээр дараарай ⑧.
- Асуултууд нь хэнд хамааралтай байхыг сонгоорой (хайх ⑨ болон шүүлтүүр ⑩ функцийг ашиглаарай). Дасгалын төрлүүдээс сонгоод тоглоомыг эхлүүлээрэй.

Хариултыг өгөхөд хязгаатай хугацаа байгаа ба нэг тоглоомын дотор гурван удаа л буруу хариулж болно. Дасгалуудыг цаашид Дасгал засварлагчаар үргэлжлүүлэн засварлах боломжтой.






## Гайхалтай туршилтууд, тоглоомууд

Механик хэрэгслийн тусламжтайгаар бодит физикийн орчинд динамикийн хуулиуд болон янз бүрийн хүчний үйлчлэлийн дор явагдах хөдөлгөөнүүдийг судалж үзэж болно. Механик хэрэгслийг нээгээрэй. Хэрэгслийн цуглуулгад ① буй биетүүдийг ашиглан туршилтынхаа анхны байдлыг тохируулаарай.


- Сонгосон биетүүдээ чирэн ② ширээн дээр аваачаарай,
- шаардлагатай бол хэмжээг нь өөрчилж, эргүүлж болно ③,
- биетийн түргэн цэснээс ④ цаашдын боломжуудыг (биетүүдийг хуулбарлах, устгах, түгжих эсвэл шинж чанарыг нь тохируулах) олж болно.

Тоглуулах икон дээр даран ⑤ бэлтгэсэн туршилтаа хийгээрэй.



## Бүр хялбархнаар

Байшин икон дээр ⑥ даран урьдчилан бэлтгэсэн туршилтыг, эсвэл тоглоомыг сонгоорой. Тоглуулах товчийг даран сонгосон загварыг амилуулаарай.



Уг туршилтыг эсвэл тоглоомыг дэвтэртээ зураг болгон оруулж ч болно ⑦.

## Туршаарай

Хэрвээ

- туршилтын хэрэгслүүдийн шинж чанарыг ⑧,
- тоглуулах хурдыг ⑨,
- татах хүчний хэмжээг ⑩ өөрчилбөл юу болох вэ?






## 1. Тоглоомуудыг хаанаас олох вэ?

Хэрэгслийн сангийн Тоглоомууд иконыг дараарай ①.



Таб-уудыг ашиглан хэрэгслүүд болон тоглоомуудын хооронд шилжих боломжтой ②.



## 2. Алийг нь сонгох вэ?



Хэлний, математикийн, логикийн болон анхаарал төвлөрлийг хөгжүүлэх тоглоомуудын баялаг цуглуулгаас сонгох боломжтой.

Эхлүүлэхийн тулд тоглоом дээр дараарай.



## 3. Тоглоомын зөвлөмжүүд

Тоглоомыг нээсний дараа асуултын тэмдгэн икон дээр даран ③ тайлбарыг нь уншиж болно.



## Зөвлөмж

Тоглоомыг ч бас жижиг, том икон, зураг эсвэл интерактив зүйл болгон нийтлэлдээ оруулах боломжтой ④.



## 1. Зургийн хэрэгслийг хаанаас олох вэ?

Зургийн хэрэгслийг хэд хэдэн янзаар гаргаж болно. Хэрэгслийн сангийн Гараар зурах ① эсвэл Үзэгний сав икон ② дээр дарах, эсвэл дэлгэцийн аль нэг доод булан ③ дээр даран гаргаж болно.



Ид шидэт малгай дээр ④ дарахад цаашдын функцүүд гарч ирнэ. Энэ иконтой функцүүдийн хялбар болон ярвигтай хувилбаруудын хооронд шилжиж болох өөр бусад газруудад ч тааралдах болно.




## 2. Юунд хэрэглэж болох вэ?

mozaBook-ийн зургийн функцүүдээр нийтлэлээ чөлөөтэйгөөр чимэглэж болно.

гараар зурах  
муруйнууд зурах  
текст танигч үзэг  
текст тодруулагч үзэг  
харилцааны диаграмм  
баллуур  
текст оруулах  
дүүргэх  
томьёо засварлагч  
хүснэгт




шулуун шугам зурах  
дүрс танигч үзэг  
бүдгэрэх шугам  
бийр, калиграфын үзэг  
геометрийн дүрсүүд  
хогийн сав, устгах  
сонгох, хөдөлгөх  
анимейшн үүсгэх  
геометрийн хэрэгслүүд  
медиа сан



## Зөвлөмжүүд

- Геометрийн дүрслэлд шугам, транспортир, гортигийг ашиглаж болно.
- Гар зураг, зураг болон бусад зүйлсийг хогийн савруу татан оруулж хялбархнаар устгах боломжтой.
- Хэрвээ самбар дээр ямар нэг зүйлийг зөвхөн түр зуур тодруулахыг хүсвэл бүдгэрэн алга болдог шугамыг ашиглаарай.







## 1. Юунд ашиглах, хаанаас олох вэ?

Дасгал засварлагчийн тусламжтайгаар олон төрлийн, үзэмжтэй дасгалуудыг, дасгалын хуудсыг үүсгэх боломжтой.

Хэрэгслийн сангийн Хэрэгслүүд икон дээр ① даран, Дасгал засварлагчийг сонгоорой ②.




Дасгал үүсгэхийн тулд эхний алхамдаа ямар төрлийн дасгал үүсгэхээ сонгоорой ③. Дасгал засварлагч нь хялбархан хариулт сонголтоос эхлэн нарийн төвөгтэй газрын зургийн даалгавар хүртэлх дасгалын олон төрлүүдийг агуулдаг.



## 2. Дасгалын загварууд

Уг программ нь дасгалын нэг төрөл дотор ч өөр бүтэцтэй, зохион байгуулалттай дасгалуудыг үүсгэх боломжтой загваруудыг агуулдаг. Дасгал нь өгүүлбэртэй бодлого ч байж болно, гэхдээ Медиа сангаас төрөл бүрийн мультимедиа агуулга ч бас оруулж болно.

Дасгалдаа аль загварыг ашиглахаа сонгоорой ④.



## Зөвлөмж

Дасгалдаа Медиа сангаас зураг, аудио, видео гэх мэт мультимедиа агуулгыг ч оруулж болно.




## 1. Дасгал үүсгэх

Сонгосон дасгалын загвартаа зохих текстэн болон мульти-медиа агуулгыг оруулаад, зөв хариултыг нь тохируулаарай.

Загварын зарим нэг хэсгийг өөрчилж, сонгох хариултын тоог тогтоон ①, дасгалын харагдах байдлыг ч бас ② өөрчилж болно.

Бэлэн болсон дасгалаа нийтлэлд оруулах ③, эсвэл өөр дасгалуудыг нэмэн дасгалын хуудас ч үүсгэх боломжтой.



Шинэ дасгал үүсгэхийн тулд бэлэн болсон дасгалаа хаагаад ④, шинэ дасгал нээгээрэй ⑤. Дасгалын хуудасны дасгалуудыг баруун доод икон дээр ⑥ даран харж болно. Хэрвээ бэлэн болсон бол хийсэн ажлаа дасгалын дэвтрийг нийтлэлд оруулснаар ③ хадгалах боломжтой.

## 2. Дасгалыг бодох, шалгах


Дасгалын икон дээр нь даран тоглуулж болно. Дасгалын зааврыг даган зөв хариултыг сонгож, хосыг нь олж, дараалуулаарай.



Дасгалыг хийж дууссаны дараа Шалгах иконыг ⑦ даран зөв бодсон эсэхээ шалгаарай.

## 3. Өмнө нь үүсгэсэн байсан дасгалыг хэрхэн засварлах вэ?

Хэрвээ дасгалыг хожим нь засварлахыг хүсвэл оруулсан дасгалын иконыг удаан даран, гарч ирэх дотоод цэснээс Засварлах ⑧ хэсгийг сонгоорой.





*Хэрэгслүүдийн тусламжтайгаар дасгал үүсгэх mozaBook-ийн зарим хэрэгслүүд нь тэдний автоматаар үүсгэсэн дасгалуудыг Дасгал засварлагч руу шилжүүлэн өгөх чадвартай байдаг ба ийм замаар богино хугацааны дотор сонирхолтой дасгалын хуудсуудыг үүсгэх боломжтой.*


*Дасгал үүсгэхийн тулд*

- Дасгал засварлагчийг нээх
- мөн өөрийн дасгал үүсгэх функцтэй хэрэгслийг бас нээгээрэй.



1

*Хэрэгсэл дотроос Дасгал горимыг 1 сонгоод, хэрвээ шаардлагатай бол дасгалын төрлийг бас тохируулаарай.*



*Хэрвээ хэрэглэхийг хүссэн дасгалаа олсон бол дасгалыг шилжүүлэх икон дээр 2 дарахад сонгосон дасгал нь Дасгал засварлагчид шилжин орж, тэндээ үргэлжлүүлэн засварлах ч боломжтой болно.*

## Ашиг тусууд

- Өөрийн дасгал зохиох шаардлагагүй,
- зураг хайх хэрэггүй,
- зөвхөн сэдвээ сонгоод л дасгал бэлэн болно.

*Дасгалыг дараа нь засварлах боломжтой.*





## 3D үзэгдлээр дасгал засварлах


Олон 3D үзэгдэл ч бас автоматаар дасгал үүсгэх, үүнийгээ Дасгал засварлагч руу шилжүүлэх чадвартай. Хэрвээ үзэгдлийн харагдаж байгаа харагдцанд энэ функц байгаа бол доод хэсэг дэх икон дээр дараарай ①.

Нээгдэн гарч ирэх самбараас сонгож болох дасгалын төрлүүдээс сонгоорой ②. Үүсгэх товчин дээр дарахад ③ уг дасгал нь автоматаар нээгдэн гарах Дасгал засварлагчруу шилжин орно. Өөр өөр харагдцаас өөр өөр төрлийн дасгалуудыг үүсгэх боломжтой байдаг.



## Дасгалуудыг хэрхэн бодох вэ?

- Шошгонуудыг тохирох газарт нь аваачаарай ④,
- өгсөн үгсийг текстэд оруулаарай ⑤,
- хооронд нь холбоорой, зөв хариултыг сонгоорой.




Хичээлийн сэдэвт холбогдох 3D үзэгдлийг хайж олоод тохирох харагдцыг болон дасгалын төрлийг сонгоорой. Дасгалаа үүсгэхээсээ өмнө ч засварлаж болно. Шаардлагатай бол, Дасгал засварлагчид дасгалаа үргэлжлүүлэн засварлаад ⑥, шаардлагадаа тохирсон дасгалыг бий болгоорой.




## 1. Дасгалаар хийх үйлдлүүд

Хэрвээ дасгалын хуудас тань хэд хэдэн дасгалаас тогтдог бол тэдгээрийн дарааллыг дураар өөрчилж болно. Дасгалын хуудас самбарыг ① нээгээрэй. Аль дасгалыг зөөхөө сонгоод зохих газар луу нь чирэн оруулаарай ②.




Уг дасгалаа үргэлжлүүлэн засварлаж ③, агуулгыг нь (зураг, видео, аудио, текст) чөлөөтэй өөрчилж болно. Хэрэгслийн сан дээр ④ Палитр иконыг ⑤ даран дасгалын гадаад үзэмжийг ч бас өөрчлөх боломжтой ⑥.



## 2. Дасгалын хуудасны тохиргоонууд

Хэрэгслийн сангийн Тохиргоо икон дээр ⑦ дарахад дасгалын хуудасны тохиргооны самбар гарч ирнэ. Энд хийсэн тохиргоо нь зөвхөн одоогийн дасгалд биш, харин бүхэл дасгалын хуудсанд хамаарах болно.



## Зөвлөмжүүд

- Дасгалын хуудсанд Гарчгийн хуудас, Мэдээлэл болон Дүн гэсэн хуудсыг ч бас үүсгэж болно, мөн дасгалуудыг хийж дуусах цагийн хязгаарыг бас тохируулах ⑧ боломжтой.
- Дасгалуудыг санамсаргүй дарааллаар ч бас гаргаж, залруулах, буцан ухрахыг ч бас зөвшөөрч болно.
- Бэлэн болсон дасгалын хуудсыг mozaWeb-д байршуулан ⑨, бусдад нээлттэй болгох боломжтой.
- Зарим нэг mozaBook хувилбараар дасгалуудыг гэрийн даалгавар болгон олгож ч болдог.




## 1. Дасгалын дэвтрийг юунд хэрэглэх вэ?

mozaBook-од өөрийн дасгалын дэвтрүүдийг үүсгэж, үүндээ бичиж, зурж, төрөл бүрийн цахим агуулгаар (зураг, видео, аудио, 3D үзэгдэл, дасгалууд) ч бас оруулан баяжуулж болно.

Үзэмжтэй танилцуулга, хичээлийн тойм, үзүүлэнг бэлтгэн, цахим номуудын нэгэн адилаар ашиглах боломжтой ①.

Дэвтрүүдээ mozaWeb бүртгэлдээ хадгалан, бусдад нээлттэй ч болгож болно. Онлайн синхрончлолын тусламжтайгаар дасгалын дэвтрүүдээ mozaBook программ ажилладаг ямар ч хамаагүй компьютерээс хандах боломжтой байдаг.






## 2. Дасгалын дэвтрийг хэрхэн нээх вэ?

Хэрэгслийн сангийн Нээх иконыг даран ②, Дасгалын дэвтрүүд цэсийг ③ сонгоорой.

Нээгдэн гарч ирэх цонхонд ④ таны дэвтрүүд гарч ирнэ. Дэвтрүүдийн нэг дээр даран нээгээрэй.

Хэрвээ жагсаалтад хэт олон нийтлэл байгаа бол толгой хэсэг дэх шүүлтүүрээр сэдвээр болон ангиар нь шүүгээрэй ⑤.

Тохиргоо иконыг ⑥ даран дасгалын дэвтрүүдээсээ устгах боломжтой.



## Зөвлөмж

mozaWeb дээр ч бас дасгалын дэвтрүүдэд хандах боломжтой. Татаж авах иконыг ⑦ даран, нээгдэн гарч ирэх Медиа сангийн жагсаалтаас дэвтрээ сонгоорой. Үүний дараа татаж авсан дасгалын дэвтрийг өөрийн компьютер дээрээ үргэлжлүүлэн ашиглаж болно.




## 1. Хэрхэн шинэ дасгалын дэвтэр үүсгэх вэ?

Хэрвээ нээлттэй дэвтэр байхгүй бол Хэрэгслийн сангийн Шинэ хуудас иконоор ① шинийг үүсгэх боломжтой. Хэрвээ нээлттэй дэвтэр байгаа бол энэ иконыг дарснаар дэвтэртээ шинэ хуудас нэмж болно.



Хэрвээ нээлттэй дэвтэр байгаа ба шинийг үүсгэх хүсэлтэй байгаа бол Хэрэгслийн сангийн Нээх иконыг дараад, Шинэ дасгалын дэвтэр цэсийг ② сонгоорой.



## 2. Дасгалын дэвтрийн шинж чанарыг тохируулах

Программ шинэ дасгалын дэвтэр үүсгэхийн өмнө үүний шинж чанарыг тохируулах хэрэгтэй.

- босоо, эсвэл хэвтээ форматуудаас сонгох ③,
- дэвтрийн шугамыг тохируулах,
- дэвсгэрийн зургийг сонгох ④,
- дэвтрийн хуудасны өнгийг ч бас тохируулах боломжтой.


Тохируулгыг хүчин төгөлдөр болгохын тулд энэ иконыг ⑤ дараарай.



## 3. Загвартайгаар бүр хялбархан болно


Урьдчилан тодорхойлсон бүтцүүдийн (загварууд) тусламжтайгаар санаандаа тохирсон бүтэцтэй дэвтэр үүсгээрэй.

- Загварууд таб дээр даран ⑥ загваруудаас сонгоод ⑦, хүрээндүүдэд агуулгаа оруулаарай.
- Хүрээг дасгалын дэвтрийн хуудсан дээр хөдөлгөж, хэмжээг нь өөрчилж болно.



## 4. Дасгалын дэвтрийг хадгалах

Хадгалахын тулд Хэрэгслийн сангийн Нээх икон дээр даран Хадгалах-ыг сонгоорой. Дасгалын дэвтэртээ гарчиг өгөөд ⑧, сэдэв, анги, холбогдох номуудыг болон хавтасны зургийг нь сонгоорой ⑨. Агуулгынх нь талаар товчоор бичээрэй.



## Зөвлөмжүүд

- Үзүүлэн үүсгэхийн тулд хэвтээ дэвтэр илүү зохимжтой байдаг, хичээлийн хэрэглээнд бол харин хос хуудсан форматыг сонгосон нь дээр. Дэвтрийг үүсгэхдээ хуудасны харьцааг тохируулахдаа анхаарна уу ⑩.
- Дэвтрийн шинэ хуудаснуудад нэг сонгосон бүлгээс санамсаргүй сонгогдох дэвсгэр зураг бас оруулж болно ⑪.



## 1. Дасгалын дэвтрээ юугаар чимэглэх вэ?

Дасгалын дэвтрийнхээ хуудсан дээр бичиж, зурж, төрөл бүрийн мультимедиа болон интерактив агуулгуудыг оруулж болно.

## 2. Дэвтрийн хуудсан дээр ажиллах

**Сонгох** • Хуудсан дээрх нэг зүйл дээр удаан дарвал, тойроод нэг хүрээ гэрч ирэх ба ① хуудсан дээр уг зүйлийн төрөлд тохирох засварлагч самбар гарч ирэх болно ②. Мөн Хэрэгслийн самбар дээр Сонгох иконыг дарахад ③ бас энэ самбар гарч ирэх болно. Үүнийг засварлагааны горим гэдэг.



**Өөрчлөх** • Сонгосон зүйлсийг хөдөлгөх, хэмжээг нь өөрчлөх, огтлох, эргүүлэх зэргийг хүрээний хаанаас барьснаас хамааран хийх боломжтой.

**Түргэн цэс** • Хүрээний баруун дээд булан дээр дарахад ④, уг зүйлийн түргэн цэс ⑤ нээгдэнэ, эндээс цаашдын засварлагааны боломжуудыг олж болно.

## 3. Түргэн цэс

Дэвтрийн хуудасны хаана ч хамаагүй дарахад түргэн цэс ⑥ нээгдэх ба уг цэсэнд

- анимейшний хэрэгслийн самбарыг нээх,
- дэвтэрт шинэ хуудас нэмэх,
- дэвтрийн шинж чанарыг тохируулах,
- хуудсуудаа гаргах,
- хүссэн халхлалтаа тохируулах,
- томруулах,
- туслах шугамуудыг гаргах,
- хуудсаа номын хавчуургаар тэмдэглэх,
- сонгох, оруулах,
- зүйлсийг түгжих болон устгах боломжтой.



## Зөвлөмжүүд

Текст бичихэд дэлгэцэн дээр гарч ирэх keyboard-ийг ⑦ хэрэглэж болох ба үүнийг идэвхжүүлэх, унтраахын тулд Keyboard иконыг ⑧ дараарай.


Засварлах самбарыг дэлгэцийн аль ч хамаагүй хэсэгт аваачиж, самбарын зах дээр хоёр товшин түгжих боломжтой. Байрлуулсан Тэгшитгэл засварлагчийн ⑨ тусламжтайгаар дэвтрийнхээ хуудсанд математикийн нэр томъёонуудыг хялбархнаар бичин оруулж болно.

Байнга ашигладаг зүйлсээ (Хогийн сав, Дуртай зүйлс, Зургийн сан, Тавиур, ...) mozaBook-ийн ширээн дээр икон болгон ⑩ байрлуулах ч боломжтой.





## 1. Үүнийг хаанаас олж болох вэ, мөн юунд хэрэглэх вэ?

Хэрэгслийн сангийн Засварлах самбарыг нээгээд ① Харилцааны диаграм хэсгийг сонгоорой ②. Уг хэрэгслээр биетүүдийг хооронд нь холбож болно. Биетүүдийг хөдөлгөхөд холбоос нь хэвээр үлдэнэ. Энэхүү зургийн функц нь хамаарлууд, үйл явцыг харуулахад их хэрэгтэй байдаг.



## 2. Биетүүдийг хэрхэн хооронд нь холбох вэ?


Хэрвээ Харилцааны диаграмм самбар ③ нээлттэй байгаа бол дараалан сонгосон биетүүд хоорондоо холбогдох болно.




### Зөвлөмжүүд

④ Сонгосон текстийн хайрцгийн хэлбэрийг харилцааны диаграммын самбар дээр өөрчилж болно ④.

⑤ Харилцаануудыг төрөл бүрийн шугам, сумаар дүрслэн харуулж болно ⑤.



## 3. Текстийн хайрцгийг хэрхэн үүсгэх вэ?



Харилцааны диаграмм самбарыг нээн, хоосон хэсэг дээр хоёр товшин текстийн хайрцгийг үүсгэж болно ⑥.

Үүссэн байгаа текстийн хайрцган дээр даран засварлаж болно.





## 1. Анимейшний хэрэгслийг хаанаас олох вэ?

Хэрэгслийн сангийн Засварлах цэсийг нээгээд ①, Анимейшн хэсгийг сонгоорой ②.





## 2. Анимейшн үүсгэх

**Алхам 1:** Зурах хэрэгслийг өмнө нь танилцуулсны дагуу хэрэглэн анимейшнийхээ харагдах байдлыг бэлтгээрэй: дасгалын дэвтрийнхээ хуудсан дээр зураг, хэрэгсэл, текст байрлуулах, зураг зурах гэх мэт.

**Алхам 2:** Анимейшний хэрэгслийн икон дээр дараарай. Анимейшний элементүүдийг гаргах дарааллаар нь сонгоод гарч ирэх шинж чанарыг нь тус тусад нь тохируулаарай.


## 3. Зүйлээр (энэ удаад зургаар) анимейшн хийх

- А) Анимейшний хэрэгслийн самбарыг нээгээрэй ②.
- В) Анимейшн үүсгэх зүйл дээр дараарай (зурган дээр) ③!
- С) Анимейшний хэрэгслийн самбар дээр анимейшний төрлийг сонгоорой ④.



## 4. Анимейшнийг тоглуулах

Хэрвээ таны анимейшн бэлэн болсон бол тохиргооны самбарыг хаагаад ⑤, дэвтрийн хуудасны доод талд байгаа жижиг сумуудаар гүйлгэн тоглуулаарай ⑥.









## 1. Геометрийн хэрэгслүүдийг хаанаас олох вэ?

Хэрэгслийн сангийн Засварлах самбарыг нээгээд ① Геометр хэсгийг сонгох ② эсвэл Үзэгний саван дахь геометрийн хэрэгслүүд иконыг дараарай.


## 2. Хэрхэн ашиглах вэ?

Ашиглахыг хүссэн хэрэгслийн икон дээр даран ③ дэвтрийнхээ хуудсан дээр гаргаарай. Зарим хэрэгслүүдийг өөр өөр хэсгээс нь барин өөр өөр функцээр ажиллуулж болдог. Тусламж хэрэгтэй бол хэрэгсэл дээрх асуултын тэмдэг дээр дараарай ④.

## 3. Гортиг, шугамыг ашиглах








## 1. Оруулах цэс

Энэ цэсийг нийтлэлд оруулж болох нооргууд, тэмдэглэлүүд болон холбоосуудыг үүсгэхэд ашиглаарай.



## 2. Ноорог, тэмдэглэл

Хэрэгслийн сангийн Оруулах цэснээс ① Ноорог хэсгийг сонгоорой ②. Ноорог үүсгэхийн тулд хуудасны хэмжээг, ар дэвсгэрийн хээг болон өнгийг тохируулах хэрэгтэй ③.



Ноорог дэвтэр дээр бичиж, зурж, Медиа сангаас зураг оруулж, харилцааны диаграм болон анимейшн үүсгэж болно.


Бэлэн болсон нооргийг нийтлэлдээ, дэвтэртээ оруулах боломжтой.

Хэрвээ зөвхөн бичсэн тэмдэглэл оруулах хүсэлтэй байгаа бол Тэмдэглэл хэсгийг сонгоорой ④.

## 3. Вэб холбоос, онлайн видео

Нийтлэлүүдэд вэб холбоос болон онлайн видеог ⑤ ч бас оруулж болох ба эдгээрийг mozaBook-ийн суурилуулсан хөтөч нь тоглуулах болно.

Холбоосын, эсвэл видеоны гарчгийг болон зөв URL холбоосыг оруулаарай. Хэрвээ Түлхүүр үг бас өгвөл уг холбоосыг mozaBook-ийн хайгч функцээр бас хайж олох боломжтой болно ⑥.



## 4. Хуудасны холбоос

Сонгосон нийтлэлийн тодорхой нэг хуудасруу аваачих тусгай холбоосыг үүсгэх боломжтой.

Эхний алхамд очих хүсэлтэй хуудсан дээрээ очоод, цэснээс Хуудасны холбоос хэсгийг ⑦ сонгоорой. Үүний дараа холбоосыг оруулах газартаа эргэн очоод Check икон дээр даран оруулаарай.

## 5. Номын хавчуурга


Ном, дэвтрийнхээ хуудсуудыг номын хавчуургаар тэмдэглэж болно. Дараа нь номын хавчуургын таб дээр даран уг хуудасруу эргэн очоорой.



## Дасгалын дэвтрээ хэрхэн синхрончлох вэ?

Хэрвээ та дасгалын дэвтрүүддээ хэд хэдэн компьютерээс хандахыг хүсэж байгаа бол mozaBook танд дараах хоёр боломжийг олгоно.


1. Та дасгалын дэвтрээ USB flash drive-аар синхрончилж болно, ингэвэл та интернэт холболтгүйгээр ч дэвтрээ ашиглах боломжтой.
2. Та вэб бүртгэлээрээ дэвтрээ синхрончилж болно, энэ тохиолдолд та дэвтрээ mozaBook ажилладаг ямар ч компьютер дээр нээн ашиглаж болно.



## 1. USB flash drive ашиглан синхрончлох

Нээх самбарын Синхрончлох цэс дээр дараарай ①.


Нээгдэн гарч ирэх цонхноос дэвтрээ ② мөн драйваа сонгоод ③, дунд нь байгаа сум дээр даран ④ синхрончлоорой.




Та USB flash drive-аа өөр компьютерт холбоод, Синхрончлох цэсийн эсрэг зүгрүү заах суман дээр даран дэвтрээ синхрончилж болно.

## 2. Вэб бүртгэлээр синхрончлох

Байршуулах • Хуваалцах цэснээс ⑤  
mozaWeb-д байршуулах хэсгийг сонгоорой ⑥.




Дэвтрийг хэн харж болохыг тохируулаад ⑦, хожим нь хайх үед хэрэг болох өгөгдлүүдийг өгөөрэй (Түлхүүр үгс, Сэдэв, Анги, Холбогдох боть). Дэвтрээ mozaWeb бүртгэлдээ байршуулаарай ⑧.



Татаж авах • Медиа сангийн самбар дээрхи Дасгалын дэвтэр цэсэн дээр дараарай ⑨.

Хандах боломжтой дэвтрүүдийн жагсаалтаас татаж авахыг хүссэн дэвтрээ сонгоод, Татаж авах икон дээр дараарай.




## Зөвлөмжүүд

- Дасгалын дэвтэртээ оруулсан өөрчлөлтийг вэб бүртгэлдээ автоматаар хадгалахыг тохируулж болно ⑩.
- Имэйлээр хуваалцах хэсгийг ⑪ сонгон дасгалын дэвтрээ танилууддаа имэйлээр илгээж ч болно.



## Ил тод, эмх цэгцтэй хуудсууд

mozaBook-ийн хөдөлгөөнт загваруудаар ил тодорхой бүтэцтэй дасгалын дэвтрүүд, үзэмжтэй үзүүлэнгүүдийг бэлтгээрэй. Дэвтрийн хуудсан дээрээ хүрээнүүдийг хөдөлгөж, хэмжээг нь хүссэнээрээ өөрчилж болно.




## Хэрхэн ашиглах вэ?

Шинэ дэвтэр үүсгэхийн тулд Загварууд таб дээр 1 дараарай. Нээгдэн гарч ирэх цонхноос дэвтрийн хуудасныхаа загварыг 2, стилийг 3 сонгоод, хөдөлгөөнт загвар ашиглана гэж сонгоорой 4. Тохируулгаа идэвхжүүлэхийн тулд Check тэмдгийг дараарай 5. Хэрвээ таны дасгалын дэвтэр аль хэдийн нээлттэй байгаа бол Түргэн цэсний Хуудасны шинж чанарууд хэсэг дээр даран Загварууд таб-д хандах боломжтой.



- Текстийн хүрээн дээр даран дотор нь бичээрэй 6.
- Медиа сангаас текстэд хамаарах зураг, видео болон 3D-г тохирох хүрээнд чирэн аваачаарай 7.
- Зургийн хэмжээг 8 болон текстийн хүрээний тоог 9 өөрчилж, загварыг хөдөлгөөнт болгох эсэхийг асааж, унтрааж бас болно 10.

Хүрээ бүрд өөр өөр медиа зүйлийг ашиглаж болно. Бэлэн болсон хуудасны текст дээр дарахад үүнд холбогдох зураг, видео эсвэл 3D гарч ирэх болно.






## Дасгалын дэвтрээ mozaWeb дээр нээх

mozaBook дээр үүсгэн mozaWeb-д байршуулсан дасгалын дэвтрээ mozaWeb дээр ч бас нээх боломжтой ①. Цахим номуудын нэгэн адилаар дэвтэрт агуулагдсан нэмэлтүүдийг тоглуулан, дэвтрийн хуудсыг эргүүлж болно.

## Mozaik TEACHER болон Mozaik STUDENT захиалга

- Медиа сангийн бүхэл агуулгад хандаж ②, хичээлийн сэдвээр ангилагдсан ③ хэдэн мянган интерактив зүйлсийг үзэж болно.
- Сэдвүүдэд үндэслэсэн хэрэгслүүд болон тоглоомыг ашиглах.
- Дасгал засварлагчийн тусламжтайгаар mozaWeb дээр ч бас дасгалын хуудсуудыг үүсгэн сурагчдадаа гэрийн даалгавар болгон олгож болох ба сурагчид mozaWeb дээр уг даалгаврыг хийх боломжтой.
- Дасгалын дэвтрийг нэгэн зэрэг хэд хэдэн компьютер дээр нээж, хамтран засварлаж, ажиллах боломжтой байдаг ④, мөн тэр үедээ биедээ мессеж ч бас бичиж болно (хамтын ажиллагааны горим).



## Дасгалын дэвтрүүдийг хаанаас олох вэ?

mozaWeb-рүү mozaBook-эд хэрэглэдэг онлайн хэрэглэгчийн бүртгэлийнхээ (mozaWeb бүртгэл) хэрэглэгчийн нэр. нууц үгээрээ нэвтэрч ороорой.

Хандаж болох mozaBook дасгалын дэвтрүүдийг харахын тулд Медиа сан цэсний Дасгалын дэвтэр хэсгийг ⑤ сонгоорой. Жагсаалтыг хичээлийн сэдвээр шүүж, эсвэл түлхүүр үгээр хайж болно. Сонгосон дэвтэр дээрээ даран нээгээрэй.


Интерактив агуулга	
3D	3D үзэгдэл
	Хэрэгслүүд, тоглоом
	Асуулт Хариултууд
	Зурагт толь бичиг
	3D нэвтэрхий толь бичиг
Сургалтын материал	
	Цахим хичээлүүд
	Ном
	Дасгалын дэвтэр





## 1. Нийтлэлийн текстээс хайх

Хэрэгслийн сангаас Хайх иконыг сонгоорой ①.



Гарч ирэх цэсэнд идэвхтэй байгаа нийтлэлийн текстээс хайж болно ②. Хайлтын илэрцийг mozaBook тодруулан харуулдаг.

Хэрвээ хэд хэдэн илэрц байгаа бол тэдгээрийн хооронд сумаар шилжиж болно ③, урсан гарч ирэх жагсаалтад бүх илэрцийг харах боломжтой ④.

Жагсаалтын нэг нэг зүйл дээр даран ⑤, нийтлэлд уг зүйлрүү очиж болно.




## 2. mozaBook-ийн функцийг болон хэрэгслийг хайх

Төв цонхны толгой хэсэгт байгаа томруулдаг шил иконыг дараарай ⑥. Нээгдэн гарч ирэх самбарт хайлтын түлхүүр үгийг бичээрэй ⑦. Олсон илэрцийн жагсаалтад mozaBook-ийн уг өгсөн түлхүүр үгэнд тохирох функцүүд, хэрэгслүүд болон нийтлэлүүд гарч ирэх болно.



Аль нэг илэрцийн дэргэд байх Нүдний дүрсийг ⑧ дарахад mozaBook уг функцийг, эсвэл хэрэгслийг цэсний тогтолцооноос ⑨ хэрхэн хамгийн хялбараар олж болохыг харуулна.

Нэг зүйл дээр дарвал mozaBook нь уг функцийг, хэрэгслийг эхлүүлэх, эсвэл нийтлэлийг нээх болно.



**Зөвлөмж** • Хайх самбарын тусламж-тайгаар програмаас гарах шаардлагагүйгээр интернэтээс хайх боломжтой ⑩.








## 1. Тусламжийг хаанаас олох вэ?

Хүрээний баруун дээд хэсэгт байгаа асуултын тэмдгийг ① дарахад гарч ирэх mozaBook-ийн тусламжаас бүх функцийг хэрэглээнд ерөнхий туслалцааг авч болно.

Зарим нэг хэрэгсэлд холбогдох тусламжид шууд уг хэрэгслийн цонхны толгой дахь асуултын тэмдэг дээр даран ② хандаж болох ба эндээс цаашдын боломжуудаас ч сонгох боломжтой.

 mozaBook тусламжийг нээх ③.


 mozaBook-ийг болон байршуулсан хэрэгслүүдийн хэрэглээг хөнгөвчлөх видео тусламжийг нээх ④.







## Хайх

mozaBook тусламж нь сэдвээр ангилсан байдаг. Та сэдвүүдийн хооронд шилжиж ⑤, мөн үндсэн хуудас руу хэзээ ч буцаж ирэх ⑥ боломжтой.

Тусламжийн цонхны доод талд байрлах хайх талбар нь ⑦ танд өөртөө шаардлагатай тусламжийг олоход туслах болно.




## Зөвлөмжүүд

-  Эхний алхмууд цэсийг сонгон ⑧ mozaBook-ийн хамгийн их хэрэглэгддэг функцүүдтэй танилцаж болно.
-  Программын хэрэглээний талаар зөвлөгөө, зөвлөмжийг авч болно ⑨.
-  Хэрвээ таны компьютер дээр олон хэлтэй mozaBook суулгагдсан байгаа бол хэрэгслийн хэлийг ч тохируулж болно.
-  Хэрэгслийн ажиллагаатай холбоотой санал хүсэлтийг бас илгээх боломжтой ⑩.



## 1. Мультимедиа бичигч гэж юу вэ, хаанаас олох вэ?



Энэ функцээр дэлгэцийн агшинг хадгалж, дуу болон видео бичлэг хийх боломжтой. Эхлүүлэхийн тулд Хэрэгслийн сангийн Дэлгэцийн агшин иконыг 1 дараарай.



## 2. Дэлгэцийн агшинг хадгалах



Дэлгэцийн агшинг ямар төрлөөр хадгалахаа цэснээс сонгоод дэлгэцэн дээр хадгалахыг хүссэн хэсгээ сонгоорой. Ингэж хадгалсан зурагнуудыг дараа нь Хадгалсан дэлгэцийн агшин хавтаснаас 2 нийтлэлдээ хэзээ ч хамаагүй оруулах боломжтой болно.

## 3. Дууны бичлэг хийх

Хэрвээ таны компьютерт микрофон байгаа бол mozaBook-ийн аудио бичигчээр бичлэг хийх боломжтой. Ингэхийн тулд Аудио бичигч цэсийг сонгоорой 3. Бичлэгийг эхлүүлэхийн тулд REC товчлуур дээр дараарай.



Бичлэгийг зогсоосны дараа автоматаар тоглуулж эхэлнэ. Бичлэгээ нийтлэлдээ оруулж болно 4, бас дараа нь Медиа сангийн Аудио бичигч самбараас хандаж ч болно.



## 4. Дэлгэцийн видео бичлэг хийх

Видео бичигчээр дэлгэцэн дээр болж буй үйл явдлыг бичин авч, хэрвээ компьютерт тань микрофон байгаа бол дууны бичлэг ч бас хийх боломжтой. Үүний тулд Видео бичигч цэсийг сонгоорой 5.




mozaBook-ийг нуух икон дээр даран 6 mozaBook-ийг, эсвэл таны компьютер дээр ажиллаж байгаа өөр бусад программыг бичихийг сонгож болно. Мөн бүхэл дэлгэцийг бичих, эсвэл зөвхөн нэг хэсгийг нь бичихийг ч бас тохируулах боломжтой 7. Хийсэн бичлэгүүддээ Медиа сангаас болон бичигч самбаруудаас бас шууд хандаж болно 8.



## 1. Хэрхэн хэвлэх вэ?

mozaBook-ээс дасгалын дэвтрийнхээ дурын хуудсыг, эсвэл бүр бүхлээр нь хэвлэж гаргах боломжтой. Шууд принтерээр хэвлэх, эсвэл файлууд хэвлэж ч болно.

Функцэд хандахын тулд Хэрэгслийн сангийн Нээх икон дээр даран ①, нээгдэн гарч ирэх цэснээс Хэвлэх хэсгийг сонгоорой ②.



## 2. Принтер дээр шууд хэвлэх

Хэрвээ таны компьютер принтерт холбогдсон байгаа бол урсан гарч ирэх цэсэнд ③ принтерийн нэр дээр даран шууд хэвлэхийг сонгож болно ④.

Принтерийнхээ төрлөөс хамааран дараах зүйлсийг тохируулаарай.

- Хэвлэхийг хүссэн хуудсуудаа тохируулах ⑤
- Цаасны хэмжээг сонгох ⑥
- Захыг тохируулах ⑦
- Нэг цаасан дээр хэдэн хуудсыг хэвлэхийг тохируулах ⑧
- Өнгөт, эсвэл хар цагаанаар хэвлэхийг сонгох
- Цаасны нэг, эсвэл хоёр тал дээр нь хэвлэх эсэх
- Дасгалын дэвтрийн аль элементүүдийг (иконууд, хуудасны дугаар, хүрээ, шугам, ар дэвсгэр) хэвлэлтэд харагдуулахыг тохируулах ⑨.



## 3. Файлд хэвлэх

Файлд хэвлэх тохиолдолд ямар форматтай (png, jpg, pdf эсвэл Microsoft XPS) файл үүсгэхийг сонгох боломжтой. Энэ файлаа нийтлэлдээ оруулах, эсвэл дараа нь хэвлэх боломжтой.



## Зөвлөмж

Хэвлэх цэсийн харагдцын цонхонд ⑩ таны тохируулгууд хэвлэлтэд, гаргах файлд ямар нөлөө үзүүлэхийг даган харж болно.



## 1. Хэзээ, юунд ашиглаж болох вэ?

mozaBook-ийн гар бичмэл таних функц нь дэлгэцэн дээр гарах keyboard-ын товчлуурыг дарахын оронд интерактив самбар дээр гараар ч бичих боломжийг олгодог.

## 2. Системийн шаардлагууд

mozaBook-ийн гар бичмэл таних функцийг зөвхөн Windows 7 болон үүнээс хойших үйлдлийн систем дээр ашиглах боломжтой.

Мөн гар бичмэл танигч нь аль хэл дээр бичсэн үгийг таних нь компьютер дээр суулгасан хэлний багцаас хамаарах болно ①.


## 3. Хэрхэн хэрэглэх вэ?

Хэрэгслийн сангийн Гараар зурах икон дээр дараад ② самбар дээр бичээрэй ③.

Бичсэн зүйлээ сонгоод Түргэн цэснээс ④ Таних хэсгийг ⑤ сонгоорой.

Нээгдэн гарч ирэх самбар дээр бичвэрийг таньсан хувилбарууд гарч ирнэ ⑥.

Зөв хувилбар дээр дарахад mozaBook нь таны гар бичмэлийг текст болгон хувиргаж ⑦, текст зүйл болгон авч үзэх болно.



## 4. Гар бичмэл танигчийг ашиглан хайх


Гараар бичсэн хэсгийг сонгоод түргэн цэснээс Хайх хэсгийг сонгоорой ⑧. Энэ үед гар бичмэл танигчийн таньсан хувилбарууд гарч ирэх болно. Энэ жагсаалтаас хайхыг хүссэн үгээ сонгоорой ⑨. Мөн вэбээс, зургийн сангаас болон нээлттэй байгаа нийтлэлээс ч хайж болно ⑩.

Мөн хайлтыг эхлүүлэхдээ гараар бичсэн үгээ шууд mozaBook-ийн хайгчруу чирэн оруулж ч болно. Энэ үед гар бичмэлийг автоматаар танин, таньсан хувилбарын дагуу хайх болно.



## Олон талт тохиргоо

Та mozaBook-ийн хэрэглэгчийн интерфэйсийг өөрийн өдөр тутмын хэрэгцээнд тохируулан өөрчлөх боломжтой.




### 1. Ширээний иконууд

Байнга хэрэглэдэг функцүүдийн иконуудыг (хогийн сав, дуртай зүйлс, үзэгний сав, медиа сан) дэлгэцийн аль хамаагүй хэсэгт байрлуулан, тэндээсээ нээх боломжтой ①.

Хэрэгслийн сангийн Тохиргоо иконыг дараад ②, Харагдах байдал цэснээс ③ Ширээний иконууд хэсгийг сонгоорой.

Иконууд дээр даран ④ алийг нь ширээн дээр байрлуулахаа сонгоорой.




Төв цонхны толгойноос ч бас Ширээний иконууд цэсэнд хандан ⑤, ширээн дээр байрлуулах иконуудыг идэвхжүүлж, унтраах боломжтой.

### 2. Хажуугийн самбар болон Бүтэн дэлгэцийн горим

Ширээний баруун ба зүүн зах дээр хоёр жижиг таб байгаа ⑥. Эдгээр табууд дээр даран хажуугийн самбарыг ⑦ болон нооргийг ⑧ нээх, эсвэл шинэ дасгалын дэвтэр үүсгэх боломжтой. Хажуугийн самбарыг ангийн самбарын хажуугаас ч чөлөөтэй хүрэх боломжтой тул үзүүлэн танилцуулахад илүү эвтэйхэн болно.

Дээр нь байгаа жижиг гурвалжинг даран хааж болно. Мөн Бүтэн дэлгэцийн горимруу ч бас шилжих боломжтой ⑨. Энэ горимд хуудас эргүүлэх сумнуудын дэргэд байрлах жижиг иконыг ашиглан бүтэн дэлгэцийг горимоос гарч, эсвэл цэсийг нээх боломжтой ⑩.




### 3. Тохиргоо цэс ⑪

- Харагдах байдал – Цэс, Хэрэгслийн сан, Хажуугийн самбар, Үзэгний савыг харуулах, Цэсийн байрлал; хуудас эргүүлэх, толгой, ар дэвсгэр; товчнууд, иконуудын хэмжээ, стиль; цонх томруулах.
- Ажиллагаа – Нийтлэлүүд, нэмэлтүүд mozaWeb-ийн хэрэглээ; хөтөч, хадгалах.
- Хулгана, мэдрэгч – Хулганы функцүүд, хүснэгтийн функцийг тохируулах.
- Ширээний иконууд – Ширээний иконуудыг гаргах, асаах - унтраах.
- Хэл – mozaBook болон keyboard-ын хэлийг тохируулах.
- Бүртгэл – Нэвтрэх аргыг тохируулах, нэр, нууц үг солих, хандах эрхүүд.
- Статистик – Статистик хийхийг зөвшөөрөх, хориглох.
- Систем – mozaBook файлуудыг зохицуулах, хадгалах, түүх.



## Гэрийн даалгаварыг шинэ маягаар

mozaBook-ийн Дасгал засварлагчаар үүсгэсэн дасгалуудыг гэрийн даалгавар болгон илгээх ч боломжтой. mozaBook-ийн тусламжтайгаар олгосон даалгавруудыг хичээл заадаг ангиуд, дугуйлангууд, бүр сурагч тус бүрээр нь ч ангилан бүртгэж, удирдах боломжтой тул гэртээ мартсан, хийгээгүй гэрийн даалгавар гэж байхаа бүрмөсөн болих болно.



Програм нь сурагчдад олгосон гэрийн даалгаврын сэдэв, буцааж илгээх хугацааны талаар имэйлээр мэдэгдэх болно.



Сурагчид мэдэгдлийн имэйл дэх Гэрийн даалгавар холбоос дээр даран олгосон даалгаврыг нээж, онлайнаар хийх боломжтой.


## Уг системийн ашигтай тал нь юу вэ?

- Олгосон ба буцааж илгээсэн даалгавруудыг бүртгэдэг учраас сурагчдын гэрийн даалгаврын гүйцэтгэлийг хянах, алхмуудыг мөрдөн дагах нь илүү хялбар болно.
- Программ нь хариултыг автоматаар үнэлэн, дүнгийн статистикийг гаргадаг, үүгээрээ багш нарын ажлыг хөнгөлж өгдөг.
- Даалгаврыг онлайнаар, ямар ч хамаагүй вэб хөтөч дээр хийж болдог.



## Гэрийн даалгаврыг хэрхэн олгох вэ?

mozaBook нь өмнө нь tozaWeb-д байршуулсан дасгалуудыг сонгосон бүлэгт гэрийн даалгавар болгон олгох боломжийг олгодог.




Хэрэгслийн сангийн Гэрийн даалгавар икон дээр дараад ①, Шинэ гэрийн даалгавар олгох цэсийг сонгоорой ②.

② Шинэ гэрийн даалгавар  
② Гэрийн даалгавар шалгах  
② Миний даалгаварууд  
Бүлэг  
⑨ Бүлгийн удирдлага

①

Нээгдэн гарч ирэх цонхонд гэрийн даалгаврын тохируулгыг гүйцэтгэж болно.




③

④

Title	Subject	Grade	Author	Date
The ear and the mechanism of hearing	Biology	7	Vass Tibor	29/03/2017
Watt's steam engine	Physics	7	Vass Tibor	29/03/2017

Title	Subject	Grade	Author	Date
Maths quiz	Maths	7	Vass Tibor	29/03/2017
Earth	Earth	7	Vass Tibor	29/03/2017
Elephant	Maths	5	Vass Tibor	29/03/2017
Acropolis	Maths	5	Vass Tibor	29/03/2017



⑤

⑥

⑦

⑧

Please enter a title and deadline for the homework assignment

Title: Physics - 29-01-2018  
Subject: Physics  
Start date: 29-01-2018 14:10  
Deadline: 05-02-2018 14:10

Instructions: Please write here the instructions for the exercise... (optional)

Students: Class B, Olga Pushkina, David Nuno Rebelo

Selected worksheets:

The ear and the mechanism of hearing	Subject: Biology Grade: 7	Vass Tibor
Watt's steam engine	Subject: Physics Grade: 7	Vass Tibor

## Тохируулга

- Дасгал, дасгалын хуудсаа сонгоорой ③. Хичээлийн сэдэв ба ангиар шүүх шүүлтүүр нь байршуулсан болон хандаж болох дасгалуудыг цэгцлэхэд дэм болно. ④.
- Хэнд дасгал олгох гэж байна? Бүлгийг сонгох ⑤, эсвэл нэг нэг сурагчдыг дангаар нь сонгох боломжтой ⑥!
- Дасгалыг хийх хугацааг өгөөрэй ⑦.
- Шаардлагатай бол дасгалдаа нэмэлт заавар бас өгч болно ⑧.

**Зөвлөмж** • Танд tozaWeb платформ дээр ч бас бүлгүүдийг удирдах, мөн хийж дууссан гэрийн даалгавруудтай холбоотой өгөгдлүүдийг харах боломж бий. Энэ функцүүдэд мөн tozaBook дээр Гэрийн даалгавар самбараас ч шууд хандаж болно ⑨.



## mozaWeb-д дасгалын хуудсыг байршуулах

Та mozaBook-ийн Дасгал засварлагч дээр үүсгэсэн дасгалууд, дасгалын хуудсуудаа mozaWeb-д байршуулан, бусад хүмүүст ч нээлттэй байхаар тохируулж, эсвэл гэрийн даалгавар болгон олгож болно.

Дасгалыг байршуулахын тулд нийтлэлд оруулсан икон дээр даран түргэн цэснээс mozaWeb-д байршуулах функцийг сонгоорой ①.

Нээгдэн гарч ирэх цонхонд

- дасгалдаа нэр өгч ②,
- хайлтын түлхүүр үг өгч ③,
- сэдэв, анги болон холбогдох нийтлэлийг өгөөд ④,
- хүндийн түвшинг тохируулаарай ⑤.

Дасгалаа байршуулахынхаа өмнө mozaWeb дээр аль бүлгүүдэд харагдуулах хүсэлтэй байгаагаа шийдээд, сонгоорой ⑥.

Title	Subject	Grade	Author	Created
Maths quiz	1	7	Vass Tibor	29/03/2017
Earth	1	7	Vass Tibor	29/03/2017
Watt's steam engine	1	7	Vass Tibor	29/03/2017
Elephant	1	5	Vass Tibor	29/03/2017
Acropolis	1	5	Vass Tibor	29/03/2017
The ear and the mechanism of hearing	1	7	Vass Tibor	29/03/2017
Birds, Mammals	1	4	Vass Tibor	29/03/2017

## Зөвлөмж

Хэрвээ аль нэг нийтлэлд оруулсан дасгалыг тэр дор нь гэрийн даалгавар болгон олгоё гэвэл үүнийг ганцхан алхмаар хийж болно.

- Гэрийн даалгавар самбараас өмнө нь танилцуулсан Шинэ гэрийн даалгавар олгох цэсийг сонгоорой,
- сонгосон дасгалын иконыг нээгдэн гарч ирэх цонхонд чирэн оруулаарай ⑦,
- өмнөх зааврын дагуу тохиргоог хийсний дараа сонгосон бүлэгт гэрийн даалгавар болгон олгоорой.




## Нэгэн зэрэг хэд хэдэн компьютер дээр

Сурагчид хичээл дээрээ ширээний компьютер, эсвэл таблет хэрэглэдэг бол багшийн компьютер, эсвэл интерактив самбар дээр ашиглаж буй mozaBook программд холбогдох боломжтой байдаг.

Ийнхүү сурагчид өөрсдийн төхөөрөмж дээрээ олгогдсон дасгалуудыг харж, бодож, багшийн илгээсэн цахим агуулгыг тоглуулах боломжтой болно.



Хувь хүнд тохируулсан дасгалууд, бие даасан, эсвэл бүлгийн ажил гүйцэтгэх, IT төхөөрөмжүүдийг зохих зориулалтаар ашиглах.




## Багш нь...

- зураг, дүрслэл, дэвтрүүдийг сурагчдын төхөөрөмжрүү илгээх
- ганцаарчилсан, эсвэл бүлгийн даалгавар олгох
- дугуйланг зохион байгуулж, удирдаж, хянах
- даалгаврын гүйцэтгэлийн явцыг даган мөрдөх
- буцааж илгээн, автоматаар үнэлэгдсэн хариултуудыг харах
- дүнгийн статистикийг хүлээн авах боломжтой.




## Ангийн ажилд хэрхэн нэгдэх вэ?

Хэрэгслийн сангийн Гэрийн даалгавар икон дээр дараад ①, Холболт үүсгэх цэсийг сонгоорой ②. Холболтыг үүсгэн ангийн ажлыг эхлүүлээрэй.





Үүний дараа сурагчид дотоод сүлжээгээр, эсвэл интернэтээр таны компьютер дээр ажиллаж байгаа mozaBook программд холбогдох боломжтой болно. Үүнд:

- Төхөөрөмж дээрээ mozaBook программыг нээх
- Сурагч холбогдох ③ цэсээр ангийн ажилд холбогдох хэрэгтэй.



## Багшийн удирдах самбар

Ангийн ажил самбар дээр холбогдсон сурагчдын төлөвийг хянаж ④, олгосон дасгалыг гүйцэтгэлийг алхам алхмаар даган мөрдөж ⑤, эсвэл нэгтгэсэн тоймыг ч бас гаргаж болно ⑥.



## Агуулга илгээх

Зураг, дүрслэл, дэвтрүүд, номуудын түргэн цэснээс, мөн 3D үзэгдлүүд болон Дасгал засварлагчийн Ангийн ажил икон дээр ⑦ даран холбогдсон сурагчдын төхөөрөмжрүү агуулгууд, даалгавруудыг илгээх боломжтой.

**Зураг, дүрслэл илгээх**  
Сурах бичгээс зураг, дүрслэлийг илгээж, мөн интернэтээс дүрслэн үзүүлэх материалыг илгээж ч болно.



## Сурах бичгийн, дасгалын дэвтрийн хуудсыг илгээх

Сурагчдын төхөөрөмж дээр нээсэн ном, дасгалын дэвтрийнхээ харагдаж байгаа хуудсыг харуулах боломжтой ба ингэснээр сурагчид хуудсыг эргүүлэхгүйгээр таны харуулахыг хүссэн зүйлийг харах болно.

**Зөвлөмж** • Нэг нэр дээр юмуу аватар дээр даран түргэн цэснээс сурагчдын төхөөрөмж дээр гарч буй агуулгыг хянах боломжтой ⑧.





## Даалгавар олгох, хийх

mozaBook дээр үүсгэсэн дасгалуудыг ангийн ажилд холбогдсон сурагчдад, дугуйланд хоёр өөр янзаар илгээх боломжтой.




## Бүхэл дасгалыг илгээх

Сурагчид өөрсдийн төхөөрөмж дээр бүхэл дасгалыг харан ②, төхөөрөмжөө ашиглан уг дасгалыг хийж, хариуг нь буцаан илгээх боломжтой.

## Хялбарчилсан даалгавар олголт

Сурагчид өөрсдийн төхөөрөмж дээр зөвхөн хариулах боломжтой ①, дасгалуудыг багшийн удирдах самбар дээр харна. Дасгалыг багшийн хяналтын дор, нэгэн зэрэг хийнэ. Дата урсгал маш бага тул бага хүчин чадалтай дотоод сүлжээгээр ангийн ажлыг явуулах боломжтой байдаг.



## Хариултыг үнэлэх

Хариулт горим дээр ③ хариултауд дасгал тус бүр дээр, эсвэл сурагч бүр дээр үнэлгээ өгч болно.

Санал өгөх горимд ④ сурагчид тавьсан асуултад нэргүйгээр хариулах боломжтой ба багш зөвхөн тухайн хариултыг хэдэн сурагч сонгосныг харах болно.



	1	2	3	4	5	6	7	8	9	10	%
Abdul Ghafoor	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	⌚	80
Brooks Pulsipher	✗	✓	✓	✗	⌚						20
Dalton Seamster	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	100
Dania Tufford	✓	✗	✓	✓	✓	✓	✗	✗	✗	✗	50
Eddie Denn	⌚	✓	✓	✓	✓	⌚					40
Elias Surls	⌚	✗	⌚								0
Gerard Willocks	✗										0
<b>Σ Total</b>	<b>50</b>	<b>83</b>	<b>83</b>	<b>67</b>	<b>50</b>	<b>50</b>	<b>33</b>	<b>33</b>	<b>17</b>	<b>17</b>	<b>48</b>



## Бүх платформ дээрх олон төрлийн хэрэглээ

Та цахим номоо mozaBook дээр юмуу mozaWeb-ийн онлайн платформ дээр нээж болно. Эсвэл таблет дээрээ mozaBook апп-ыг татаж аваад цахим номоо уншаарай.

Үйлдлийн системээс хамаараад (iOS, Android), таблет дээр зарим нэг интерактив нэмэлт агуулга нь зөвхөн хязгаарлагдмал функцээр ажилладаг. mozaBook-ийг бүрэн дүүрэн ажиллагаагаар нь хэрэглэхийн тулд Windows үйлдлийн систем шаардлагатай.

mozaBook нь мэдрэгч дэлгэцтэй төхөөрөмжүүдийг дэмжин, дэлгэцийн хэмжээнд ухаалгаар зохицдог тул интерактив самбар, нөүтбүүк болон таблет дээр нэгэн адилаар ашиглах боломжтой байдаг.



mozaBook нь манай вэб дэлгүүрт сурагчдад, багш нарт болон танхимын хэрэглээнд зориулсан хэд хэдэн хувилбараар байдаг.





## iOS болон Android хэрэглэгчдэд

App store-оос, эсвэл Google Play-гээс mozaBook апп-ыг татаж аваарай.

Өөрийн дотоод хэрэглэгчийг үүсгэн өөрт байгаа mozaWeb онлайн хэрэглэгчийн бүртгэлтэйгээ холбон өмнө нь худалдаж авсан цахим номнууддаа хандаарай.

Хэрвээ танд mozaWeb бүртгэл байхгүй бол шинэ бүртгэл үүсгээрэй.



-  Та өөрт байгаа номнуудаа таблетрүүгээ татаж авах, эсвэл шинэ нийтлэл худалдаж авах ч боломжтой. (Татаж авсны дараа mozaBook-ийг офлайнаар ч ашиглаж болно.)
-  Цахим сурах бичигнийхээ хуудсыг эргүүлж, хуудасны хэсгүүдийг нь томруулж, байрлуулсан интерактив нэмэлт агуулгыг нь (3D үзэгдлүүд, сургалтын видеонууд, зургууд, аудионууд болон дасгалууд) тоглуулж болно.
-  Номныхоо хуудсан дээр зураг зурж, текст тодруулагчийг ашиглаж, тэмдэглэл оруулж ч болно.
-  Ширээний компьютер дээр, эсвэл интерактив самбар дээр ажиллаж буй mozaBook программд холбогдож болно (ангийн ажилд).



## Интерактив ангийн ажил ба гэртээ суралцах

Хэрвээ та mozaBook-ийг интерактив самбарыг ашиглан, сурагчид планшетаар хангагдсан байгаа бол бүлгээр ажиллах ангийн ажлыг эхлүүлэх боломжтой болно.

Сурагчид багшийн компьютертэй интернэт холболтгүйгээр, утасгүй сүлжээгээр холбогдож болно. Та сурагчдадаа интерактив гэрийн даалгавар олгож, сурагчид гэрийн даалгавраа гэртээ, компьютер дээрээ хийх боломжтой.

Сурагчид ангийн ажилд оролцох, мөн гэрийн даалгавар хийхийн тулд Mozaik STUDENT захиалгатай байх ёстой.



## Mozaik STUDENT pack

Mozaik STUDENT захиалгыг сурагчид бие даан худалдан авах боломжтой ч, багцаар нь худалдан авбал ангиараа хөнгөлөлттэйгөөр авах боломжтой.

Нэг дор 10 эсвэл үүнээс олон захиалгыг хөнгөлөлттэй багцаар, багагүй үнийн хямдралтайгаар худалдан авах боломжтой.



## Mozaik STUDENT захиалга

### Ангид

- Таблетаараа багшийн эхлүүлсэн ангийн ажилд нэгдэх боломжтой.
- Зураг, интерактив апп, текст болон дасгалын хуудсуудыг хүлээн авах боломжтой.
- Тэдэнд илгээсэн даалгаврыг хийх боломжтой.

### Гэртээ

- Цахим нийтлэлүүдийг нээж, тэдгээрийн агуулсан интерактив агуулгыг тоглуулах боломжтой.
- Медиа санг хязгааргүйгээр ашиглах боломжтой.
- Ур чадвар хөгжүүлэх, дүрслэн үзүүлэх болон виртуал лабораторийн апп-уудыг ашиглан тоглонгоо суралцах боломжтой.
- Интерактив гэрийн даалгавраа хийж, тэдэнтэй хуваалцсан үзүүлэнг үзэх боломжтой.



## Хэрхэн ашиглаж болох вэ?

mozaBook app нь таблет дээр болон гар утсан дээр ч ажилладаг ба иймээс сурагчид цахим сурах бичгээ байнга өөртэйгээ авч яван, офлайн хэрэглэх ч боломжтой байдаг.

Интернэтэд холбогдсон компьютер дээр mozaWeb хуудсанд тусгай программ суулгах шаардлагагүйгээр цахим номууд, дэвтрүүдийг нээж болох ба интерактив агуулгууд, сургалтын хэрэгслүүдийг хязгааргүйгээр ашиглах боломжтой байдаг.





## Программыг шинэчлэх

mozaBook системийг нь байнга хөгжүүлж байдаг. Үүнд агуулагдах цахим сургалтын агуулгууд, хэрэгслүүдийн тоо байнга өргөжиж байдаг тул хэсэг хугацаа бүрд шинэчлэх шаардлагатай болдог.

Хэрвээ таны хэрэглэж буй программын шинэ хувилбар бэлэн байгаа бол программыг эхлүүлэх үед үүнийг анхааруулсан мессеж гарч ирэх болно ①. Суулгах-ыг сонгоод ②, программаа шинэчлээрэй!



**Зөвлөмж** • Програмаа толгой хэсэгт байгаа икон дээр даран ③, эсвэл Тохиргоо самбарын Шинэчлэх цэсийг сонгон ④ дараа нь ч шинэчлэх боломжтой.



## Санал хүсэлт илгээх

Хэрвээ танд mozaBook-ийн ажиллагаатай холбоотой санал хүсэлт байгаа, эсвэл манай аль нэг нийтлэл нь алдаатай байгаа бол энэ талаар бидэнд мэдэгдэнэ үү. Тохиргоо самбараас Санал хүсэлт хэсгийг сонгоорой ⑤.

- Нэр, имэйл хаягаа өгөөд,
- юу анзаарсныгаа бичнэ үү ⑥,
- алдаа олсон бол үүний байгаа газрыг тодорхойгоор бичээрэй,
- шаардлагатай бол дэлгэцийн агшин, видеог хавсаргах, эсвэл холбогдох нийтлэлийг байршуулсан ч болно ⑦.





## Лицензүүдийг харьцуулах

mozaBook програмыг сургуулиуд, багш нар, эцэг эхчүүд болон сурагчдын аль аль нь, хичээл дээрээ болон гэртээ хэрэглэх боломжтой байдаг.

Хэрэглэгчдийн өөр өөр хэрэгцээнд тохирсон өөр өөр төрлийн mozaBook хувилбарууд бий. Хэрэглэгчийн лицензүүд (Mozaik STUDENT, Mozaik TEACHER) -ийн тусламжтайгаар хэрэглэгч нь өөр өөр төхөөрөмжүүд дээр (компьютер, интерактив самбар, нөүтбүүк, гар утсан дээр) өөрийн бүртгэлээрээ нэвтрэн орох боломжтой. mozaBook болон mozaWeb системийн аль алиныг нь ашиглах боломжтой, гэхдээ нэг зэрэг нэг л төхөөрөмжөөс нэвтрэн орох боломжтой.

Төхөөрөмжид суурилсан лиценз (mozaBook SCHOOL-LAB, mozaBook CLASSROOM)-ийн тусламжтайгаар нэг ижил төхөөрөмж дээр хязгааргүй тооны хэрэглэгч ашиглах боломжтой болно. Хэрэглэгч тус бүрд лиценз байх шаардлагагүй. Энэ лицензийн төрөл нь нэг төхөөрөмжийг хэд хэдэн багш, сурагч ашигладаг үед зохимжтой байдаг. Нэг ёсондоо хэрэглэгчийн тоог үл харгалзан, төхөөрөмжид лиценз авна гэсэн үг юм.

mozaBook лицензүүд	Хэдэн хэрэглэгч ашиглаж болох вэ?	Үүнийг хэдэн төхөөрөмж дээр ашиглах боломжтой вэ?	mozaBook нийтлэлүүдийг нээх эрхтэй	Хэрэгсэл, тоглоомуудыг ашиглах	Видео, 3D, Цахим хичээл, Зураг, Аудио	Өөрийн үзүүлэн үүсгэх (дасгалын дэвтэр)	mozaWeb системийн хэрэглээ	PDF-ээс өөрийн цахим ном үүсгэх	Интерактив 3D номын цуврал (20 боть)	Интерактив самбар / Проектор / Тои хэмжээтэй дэлгэц (>30") дээр ашиглаж болно	Бүлэг үүсгэх	Ангийн ажил	Интерактив гэрийн даалгавар
Mozaik STUDENT	нэг	хэд хэдэн	✓	✓	✓	✓	✓					холбогдож болно	хийж болно
Mozaik TEACHER	нэг	хэд хэдэн	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	эхлүүлж болно	олгож болно
mozaBook SCHOOL-LAB	хэд хэдэн	нэг	✓	✓	✓	✓						холбогдож болно	хийж болно
mozaBook CLASSROOM	хэд хэдэн	нэг	✓	✓	✓	✓		✓	✓	✓	✓	эхлүүлж болно	олгож болно



## Mozaik Education

Сегед хот • Унгар улс  
имэйл: [office@mozaweb.com](mailto:office@mozaweb.com)  
вeб хуудас: [www.mozaweb.com](http://www.mozaweb.com)



Уг нийтлэл нь Mozaik Education-ий оюуны өмч болох ба зохиогчийн эрхтэй байдаг. Уг бүтээлийг Mozaik Education-ий урьдчилсан зөвшөөрөлгүйгээр ямар нэгэн байдлаар хуулбарлах, олшруулах, орчуулах болон одоогоор мэдэгдэж буй эсвэл хойшид танигдах хэлбэрээр, төхөөрөмжөөр бүхлээр нь юмуу аль нэг хэсгийг нь ашиглахыг хатуу хориглоно.

Уг нийтлэлийг бид маш хянамгай, хичээж бүтээсэн. Гэхдээ мэдээллийн өөрчлөлт, үнэн зөв байдал, бүрэн бүтэн байдлын талаар ямар ч хариуцлага хүлээхгүй болно. Бид агуулгыг өөрчлөх эрхээ хадгална.

Copyright Mozaik Education Ltd., 2024. Бүх эрх хуулиар хамгаалагдсан.